

**ТӨВ АЙМГИЙН 2022 ОНЫ 06 ДУГААР САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ**

2022 оны 06 сарын 05-ны өдөр

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2022 оны 06 дугаар сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

НЭГ. АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

I. Аймгийн ИТХ болон Зөвлөлийн хүрээнд:

Аймгийн ИТХ-ын 10 дугаар хуралдаан 2022 оны 06-р сарын 24-ний өдөр, Хурлын Зөвлөлийн 3-р хуралдаан 6-р сарын 15, ээлжит бус 1-р хуралдаан 06-р сарын 21-ний өдөр тус тус хуралдлаа.

Аймгийн ИТХ-ын Х хуралдаанаар:

1.“Аймгийн хэмжээнд 2022 онд ахуйн зориулалтаар агнах барих агнуурын амьтдын тоо хуваарь батлах тухай” асуудлыг хэлэлцээд аймгийн нутаг дэвсгэрээс 2022 онд ахуйн зориулалтаар агнах агнуурын амьтдын тоо хуваарийг батлав.

2.Аймгийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тухай мэдээлэл, түүнд Төв аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн аудитын дүнг хэлэлцээд аймгийн 2021 оны төсвийн орлогын гүйцэтгэлийг 110,790.7 сая төгрөгөөр, зарлагын гүйцэтгэлийг 96,225.5 сая төгрөгөөр тус тус батлав.

3. Аймгийн 2022 оны төсвийн тодотгол батлах тухай мэдээллийг хэлэлцээд аймгийн 2022 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 45,102,622.0 мянган төгрөг буюу аймгийн татварын болон татварын бус орлого 6,770,140.0 мянган төгрөг, аймгийн төсөвт Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 9,202,626.5 мянган төгрөг, аймгийн төсөвт орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг 12,524,291.4 мянган төгрөг, аймаг төсвийн урьд оны үлдэгдэл 6,324,664.2 мянган төгрөг, аймгийн төсвийн тухайн жилийн төсвийн байгууллагын өөрийн орлого 11,000.0 мянган төгрөг, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдэл 540,718.7 мянган төгрөг, сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын дүн 7,759,874.9 мянган төгрөг, сумын төсөвт үлдэх төсвийн орлого, зарлагын зөрүү 1,969,306.3 мянган төгрөгөөр тус тус батлав.

Аймгийн 2022 оны төсвийн тодотголын “Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 1 дүгээр, “Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 2 дугаар, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдлийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 3 дугаар, аймгийн Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг 4 дүгээр хавсралтаар, аймгийн төсвийн ерөнхийлөн зөхирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийн өөрчлөлтийг 5 дугаар хавсралтаар, аймгийн мал хамгаалах сангийн орлого, зарлагын хэмжээг 1,500,000.0 мян төгрөгөөр тус тус баталлаа.

4.Тариалангийн бүс нутаг тогтоох талаар санал уламжлах тухай мэдээллийг хэлэлцээд аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хуралд дахин өргөн мэдүүлэхээр буцаав.

5.Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах” 06 дугаар тогтоолыг хүчингүй болгох талаар аймгийн Засаг даргын мэдээллийг хэлэлцээд

аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөрч манлай ахмад шалгаруулж, шагнах журам”-ыг хүчингүй болсонд тооцов.

6.Олон нийтийн цагдаагийн ажилтны тоо тогтоох тухай аймгийн Засаг даргын мэдээллийг хэлэлцээд аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг хамгаалах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр 2022 онд ажиллах Олон нийтийн цагдаагийн ажилтны тоог 14 байхаар тогтоолоо.

Аймгийн ИТХ-ын ээлжит 10 дугаар хуралдаанаар 6 асуудал хэлэлцэж 5 тогтоол баталлаа.

II. Нийтийг хамарсан үйл ажиллагааны хүрээнд:

Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Х.Мөнхзулаар ахлуулсан ажлын хэсэг Төв аймагт ажиллаж аймаг, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга болон хэлтэс агентлагуудын удирдлагуудад “Жендэр ба хүний эрх” сэдэвт сургалт 2022.06.21-нээс 06.22-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа.

Энэ үеэр Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын хэсэг хөдөлмөрлөх эрхийн хүрээнд аймгийн Татварын хэлтэс, Ус цаг уур орчны шинжилгээний төвийн үйл ажиллагаатай танилцаж, Комиссын гишүүний зөвлөмжийн хэрэгжилт болон хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд хяналт, шалгалт хийлээ.

III. Аймгийн ИТХ-ын Ажлын албаны хүрээнд:

Энэ 6 дугаар сард аймгийн ИТХ-ын дарга, Ажлын албанд хандсан 15 албан бичиг ирснийг бүртгэн, хариу хүргүүлэх шаардлагатай 2 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна. Аймгийн ИТХ-ын дарга, Ажлын албанд хандан иргэдээс ирсэн өргөдөл гомдол бүртгэгдээгүй.

Аймгийн ИТХ-ын дарга, Хурлын Ажлын албанаас УИХ-ын гишүүд, Ерөнхийлөгчийн тамгын газар, салбарын яамдад болон холбогдох албан байгууллагад 25 албан бичгийг гарган хүргүүлж ажиллалаа.

Төв аймгийн Бурхан шашны төвийн тэргүүн лам нарын зөвлөлийн хурал аймгийн төвд зохион байгуулах хүсэлт ирүүлсний дагуу аймгийн ИТХ-ын ажлын алба бэлтгэл зохион байгуулалтыг хангав.

Энэ сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 05-р сарын 18-ны өдрийн 86-р зарлигаар олон хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлсэн Төв аймгийн 369 “Алдарт эх” 1,2 дугаар зэргийн одонгоор шагнагдсаныг гардуулах ёслолын үйл ажиллагааг аймгийн ИТХ-ын ажлын алба Монгол туургатан театрт зохион байгууллаа.

“Алдарт эх”-ийн одон гардуулах ёслол, хүндэтгэлийн арга хэмжээнд УИХ-ын гишүүн Н.Энхболд, Ж.Батжаргал, Ц.Туваан, Монгол улсын Ерөнхийлөгчийн ахлах зөвлөх С.Лүндэг, Ерөнхийлөгчийн Хот хөдөөгийн хөгжлийн бодлогын зөвлөх О.Буяннэмэх, аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, ИТХ-ын Нарийн бичгийн дарга Ч.Жавзанпагма, аймгийн удирдлагууд, 27 сумаас хүрэлцэн ирсэн ээжүүд болон ар гэрийнхэн оролцлоо. Энэ жилийн хувьд аймгийн 27 сумын хэмжээнд “Алдарт эх”-ийн I одонгоор 43, II одонгоор 326 ээж шагнагдсан бөгөөд Төв аймгийн хэмжээнд нийт “Алдарт эх”-ийн одонтой 9361 ээж байна.

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд Төв аймгийн харьяат Улс, аймгийн алдар цолтой бөхийн “МАНЛАЙН БАЯСГАЛАН” барилдаан 2022 оны 06 дугаар сарын 11-ний өдөр аймгийн Спортын ордонд аймгийн ИТХурал, ЗДТГазар, БТСГазар, Төв аймгийн үндэсний бөхийн холбоо, Дүнжингарав бөхийн дэвжээ хамтран зохион байгууллаа.

Тус бөхийн барилдаанд МУ-ын Харцага Ө.Даваабаатар, МУ-ын начин Г.Ганжад, Д.Хүдэрбулга тэргүүтэй Улс аймгийн алдар цолтой хүчит 32 бөх барилдсанаас Өндөрширээт сумын харьяат ШШГГазар, “Хүч спорт хороо”-ны тамирчин МУ-ын начин Д.Хүдэрбулга түрүүлж, Бүрэн сумын харьяат аймгийн Начин Л.Энхтүвшин үзүүрлэж, Сүмбэр сумын харьяат Зэвсэгт хүчний 311-р анги, “Алдар спорт хороо”-ны тамирчин Монгол улсын начин Г.Ганжад, Эрдэнэсант сумын харьяат “Алдар спорт хороо”-ны тамирчин аймгийн Арслан И.Мандах нар шөвгөрлөө. Мөн тус барилдааны үеэр сумдын удирдлагууд сумаасаа төрөн гарсан Улс, аймгийн цолтой бөхчүүддээ хүндэтгэл үзүүллээ.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх талаар ард иргэдийн дунд хэлэлцүүлэг хийж, оролцоог хангах зорилгоор УИХ-ын гишүүн Н.Энхболд, аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн нар орон нутаг ажиллаж, УИХ, ЗГ-аас хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр Төв аймагт хийгдэж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын талаар мэдээлэл өгч, хүний эрхийн талаарх Үндсэн хуулийн хамгаалалтыг бэхжүүлэх, Ард түмнийг төлөөлөх парламентын хариуцлагыг нэмэгдүүлэх, Хот хөдөөгийн хөгжлийг дэмжих, нутгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, Монгол Улсын төрийн сүлдийг шинэчлэх асуудлаар ард иргэдээс санал асуулга авч ажиллалаа. Мөн сумын газар тариалангийн явц, цаг үеийн ажлуудтай танилцаж иргэдтэй уулзаж санал бодлыг нь сонсов.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах аймгийн салбар комиссын ажлын хүрээнд:

Аймгийн ИТХ-ын Ажлын алба, Төв аймгийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссоос 6-р сард хийж гүйцэтгэсэн ажлын тайлан мэдээг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисст хүргүүлж ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэлмэгдэгчдийн дурсгалд зориулан мод тарих аян өрнүүлж, 27 сумын ИТХ-д аймгийн ИТХ-ын даргын 2022 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 116, 5 дугаар сарын 17-ны 127 дугаар албан бичгээр зөвлөмж, чиглэл хүргүүлэв. Энэ хүрээнд Баянчандмань, Өндөрширээт, Аргалант, Баян-Өнжүүл, Батсүмбэр, Угтаалцайдам, Дэлгэрхаан, Алтанбулаг сумд хэлмэгдэгчдийн дурсгалд зориулсан төгөлтэй болж нийт 755 ширхэг мод тариад байна. Мөн аймгийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комисс, иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанаас Зуунмод сумын Засаг даргад хэлмэгдэгчдийн дурсгалд зориулсан төгөл байгуулах хүсэлт хүргүүлсний дагуу Зуунмод гол дагуу цэцэрлэгт хүрээлэнд газрыг шийдвэрлэлээ. Тус төгөлд аймгийн ИТХ-ын Ажлын албанаас дурсгалын пайз босгон, 2 хэлмэгдэгчдийн ар гэртэй хамтран мод тарих ажлыг эхлүүлсэн бөгөөд 3 гэр бүлээс мод тарих хүсэлт ирүүлээд байна.

27 сумдын орон нутгийг судлах музейд хэлмэгдэгчдийн дурсгалд зориулсан хүндэтгэлийн булан нээх талаар сумдын ИТХ-ын дарга нарт чиглэл хүргүүлэв. Мөн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссоос бэлтгэсэн Ч.Нэргүй “Өвөөг минь улс төрийн хилс хэрэгт хэлмэгдүүлж, аавыг минь цэргийн албанаас халж, бүх хөрөнгийг нь хурааж байсан гэдэг”, Н.Бямба “Хаалгаа тайл эсэргүүний үлдэгдлүүд гээд орилдог байсан”, С.Бөхбат “Бага байхад улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн 2 өвөөгийнхөө тухай ярьдаггүй байсан”, Д.Дамбадагва “Хэлмэгдсэн хүмүүс улс орныхоо хөгжилд оролцож чадаагүй, хувийн жамт амьдралаа ч эдэлж чадаагүй”, Ч.Бадамгарав “Хэлмэгдүүлэлтийн тухай аав минь ярихдаа хамаг бие нь чичирч, нулимс нь бөмбөрдөг байсан”, Г.Туяа “Дотоод яамны хашаанд 6 эмэгтэй хоригдож байсан гэдэг. Миний ээж цаазлуулах ял авсанаа ч мэдээгүй”, З.Өнөржаргал “Миний аав 1938 онд 20 гаруйхан насандаа хэлмэгдэж, 10 жилийн ял авч байсан юм билээ”, Ж.Тэнгэрмаа “Хэлмэгдүүлэлтийн толбо бидэнд ч тусаж байсан”,

Д.Оюунбаатар “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн хүний хүүхэд гээд биднийг их шахдаг байсан”, С.Нацагдорж “Энэ муухай хэлмэгдүүлэлтийн хар шуурга дахин битгий хойч үе залуучуудын минь дунд бүү үүсээсэй гэж боддог”, Д.Долгормаа “Манай ээж 36 насандаа баригдаж, 1 настай охин нь цор ганцаар үлдсэн”, Д.Цэрэндарьзав “Эргээд бодоход хэлмэгдүүлэлт гэж айхтар юм байжээ” зэрэг ярилцлага болон контентийг орон нутгийн Төв телевиз, аймгийн ИТХ-ын цахим хуудас болон пейж хуудсаар олон нийтэд түгээгээд байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын хүрээнд:

Цагдаагийн Ерөнхий газраас зам тээврийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” нэгдсэн арга хэмжээг орон даяар эхлүүлэв. Энэхүү арга хэмжээнд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Төв аймгийн төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагууд нэгдэж, нээлтийн арга хэмжээ зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр Төв аймаг дахь Цагдаагийн газарт хамгаалалтын түмбэ, согтуурал хэмжигч багаж, энгэрийн камер зэрэг 6.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өглөө. Мөн аймгийн Засаг даргын захирамжаар “Архигүй үлгэрлээ” 6 сарын аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулж байна.

ХОЁР. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн удирдлагуудын нэгдсэн шуурхай зөвлөгөөнийг оны эхэнд батлагдсан хуваарийн дагуу 06 сарын 06, 20-ны өдрүүдэд танхимаар 2 удаа зохион байгуулж, тэмдэглэлээр 49 заалт бүхий үүргийг холбогдох байгууллага, суманд хүргүүлж, хэрэгжилт тооцов.

“Аймгийн төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-д туссаны дагуу 06 сарын 08-ны өдөр “Иргэдтэй уулзах цаг” зохион байгуулж, аймгийн ЗДТГ-ын дарга М.Отгонбат иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, хариулт өгөв. Уг арга хэмжээний үеэр иргэдээс гарсан 7 санал, хүсэлтийг хяналтын картаар холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлж шийдвэрлэлээ. Дараа сарын “Иргэдтэй уулзах цаг” арга хэмжээг 07 сарын 06-ны өдөр зохион байгуулахаар бэлтгэл хангаж байна.

Аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлөөр аймгийн 2022 оны нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг 77.25%-тай дүгнэж хэлэлцүүлж, удирдлагаас ажил эрчимжүүлэх үүрэг, чиглэл өгөв.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байнгын ажиллагаатай 34 зөвлөл, хороо, комиссын үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор 2021 оны үйл ажиллагааны мэдээлэл, 2022 оны төлөвлөгөөт ажил, түүний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ажил эрчимжүүлэх чиглэл өглөө.

Хэлтсийн нээлттэй хаалганы өдөрлөгийг 06 сарын 23-ны өдөр зохион байгуулав. Өдөрлөгийн үеэр иргэдэд байгууллага, нэгж (Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, аймгийн Үйлчилгээний нэгдсэн төв)-үүдийн үйл ажиллагааны мэдээлэл, Тангараг өргөх болон шагнал гардуулах ёслол, ганцаарчилсан болон хэсэгчилсэн зөвлөгөө, МХГ, ОБГ-ын үйл ажиллагаандаа ашигладаг багаж, тоног төхөөрөмжийн үзэсгэлэн, зөвлөгөө, Цэргийн штабын мэдээлэл лавлагаа, E-Mongolia үйлчилгээ, Удирдлагын академи болон АЗ ХҮР номын дэлгүүрүүдийн худалдааг зохион байгуулав. Өдөрлөгийн үеэр дараах арга хэмжээг зохион байгуулав. Үүнд:

-Төрийн жинхэнэ албан хаагчийн тангаргийг 41 албан хаагч тангараг өргөж, эрхэлсэн ажилдаа үр бүтээлтэй ажилласан 11 албан хаагчийг аймгийн шагналаар шагнав.

-37 иргэнд e-mongolia апплейкешн суулгаж, ашиглах заавар олгов.

-5 төрийн албан хаагчид ганцаарчилсан зөвлөгөө, 23 иргэнд үнэгүй тоон гарын үсэг олгосон.

-АЗ ХУР болон УА-ийн номын дэлгүүрийн худалдаагаар үйлчилж иргэд, төрийн албан хаагчид нийт 588,900 төгрөгийн худалдан авалт хийж, 59,000 төгрөгийн хөнгөлөлт урамшуулалд хамрагдсан байна.

-Онцгой байдлын газраас гал түймрийн улсын хяналтын байцаагчийн ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийг 5 аж ахуй нэгж байгууллагад, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх 7 төрлийн гарын авлагыг 126 ширхэгийг тараан холбогдох хууль тогтоомжийг сурталчлан ажиллалаа.

-Мэргэжлийн хяналтын газраас ажлын байрны хэмжилтийн 7, лабораторийн шинжилгээний 10 багаж дэлгэн ундны усны химийн шинжилгээг 3 үзүүлэлтээр газар дээр нь хийж, нян судлалын шинжилгээгээр ил задгай худалдаалагдаж байгаа хүнсний бүтээгдэхүүнээс сүүлийн үед илрээд байгаа эшериха коли бактерийн бэлдэцийг иргэдэд үзүүлж, багаж тоног төхөөрмжийн болон шинжилгээний талаар мэдээлэл өгсөн. 22 нэр төрлийн хяналтын болон лабораторийн шинжилгээний дээж авах арга аргачлалын брошурыг 50 иргэн ААН-д тарааж зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллалаа.

Канад, Монгол Улсын Засгийн газрын хөгжлийн хөтөлбөр болох Мерит төслийн хамтрагч байгууллагуудын “Жендерийн манлайлагчдын клуб”-ын 06 сарын уулзалтад Төв аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн М.Доржмаа “Хөдөлмөрийн дотоод журмыг жендерийн мэдрэмжтэй боловсруулах нь” сэдвүүдээр илтгэл мэдээлэл өгч, клубийн гишүүдийн сонирхсон асуултад хариулт өгсөн.

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанаар үндсэн нэгж, сумын Засаг дарга, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ирүүлсэн 118 иргэний тодорхойлолтыг хэлэлцүүлж, холбогдох байгууллагаас дүгнэлт авч ажиллалаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилсан.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаан 2 удаа хуралдаж 21 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн. Аймгийн ИТХ-ын хуралдаанд өргөн барих 6 асуудлыг холбогдох бодлогын хэлтсүүдээс авч өргөн барисан.

Аймгийн баяр наадам зохион байгуулах хорооны нарийн бичгийн даргаар томилогдон. Зохион байгуулах хорооны хуралдааныг 2 удаа зохион байгуулж, салбар комиссуудын ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулж, зардал гаргах захирамжуудыг батлуулж наадмын бэлтгэл ажилд салбар комиссуудыг оруулсан. Аймгийн баяр наадмын худалдаа үйлчилгээний 90 зөвшөөрөл иргэдэд тараасан.

Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан аймгийн Засаг даргын шагналаар шагнуулах хүмүүсийн материалыг хүлээн авч нэгтгэн аймгийн засаг даргын захирамжаар шийдвэрлүүлсэн.

Хүний нөөцийн холбогдолтой 8 тушаалыг аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар батлуулсан. Сумд, агентлаг, газар, хэлтсийн төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, мэргэшлийн түвшин, үр дүнг үнэлсэн тайлан мэдээг нэгтгэн аймгийн ЗД-ын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.

2022 оны 6-р сарын 5-ны өдөр Бүгд Найрамдах Польш Улсын Гадаад Харилцааны сайд Збигнев Рау Төв аймагт айлчлал хийж Төв аймгийн Засаг дарга болон удирдлагуудтай уулзалт хийв. Уулзалтын үеэр БНПУ-ын Глиноецк хот болон Төв аймгийн Баян сум хоорондын найрамдалт харилцааг сэргээх талаар санал солилцов.

2022 оны 6-р сарын 23-ны өдөр БНСУ-ын Пёнгтек хотын Гадаад харилцааны газрын мэргэжилтэнгүүдтэй Пёнгтек хотын Захирагч болон удирдлагуудын Төв аймагт айлчлах айлчлалын бэлтгэл ажлын цахим хурал зохион байгуулав.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ТӨВ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ХҮРЭЭНД:

1. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Салбар зөвлөлийн 6 дугаар хуралдаан зохион байгуулагдаж 2 асуудал хэлэлцлээ. Үүнд: Салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэж холбогдох судалгаа, мэдээний хамт ТА3-д хүргүүлэхээр болов. 2 дугаар улирлын биелэлт 73.2 хувьтай байна. (100%-4, 90.0%-7, 70.0%-13, 50.0%-6, 30.0%-1, хугацаа болоогүй-1).


- Мөн Боловсрол, шинжлэх ухааны газрын 20 албан тушаалын тодорхойлолтын төслийг хэлэлцэн сайжруулалт хийж, дахин хянуулснаар ТА3-д хүргүүлэхээр боллоо.

1.2. 2022 оны эхний хагас жилийн байдлаар салбар зөвлөлийн хяналтад авсан ТА3-ийн 8 тогтоолын биелэлт дундажаар 96.25%, 5 зөвлөмжийн биелэлт дундажаар 94.0%-тай хэрэгжлээ.

1.3. Эхний хагас жилийн байдлаар төрийн захиргааны албан тушаалд хийсэн 32 зөрчилтэй томилгооны судалгааг гаргаж, холбогдох албан тушаалтанд томилгооны зөрчилгүй ажиллах чиглэлийг өгөөд байна. Үүнийг өмнөх оны жилийн эцсийн дүнтэй харьцуулбал 45-аар буурсан байна.

1.4. Тайлант хугацаанд 6 байгууллагын эрх бүхий албан тушаалтан 16 төрийн жинхэнэ албан хаагч (үүнээс: эрэгтэй 11, эмэгтэй 5; ТЗ-12, ТТ-4)-д сахилгын шийтгэл ногдуулсан бөгөөд төрлөөр авч үзвэл ганцаарчилсан хэлбэрээр сануулах 9, цалингийн хувь бууруулах 5, төрийн албанаас халах 1, хуульд заасан бусад 1 байна. Энэ нь өмнөх оноос 29 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.

1.5. Төв аймгийн төрийн 207 байгууллагаас 75.8 хувь буюу 157 нь ёс зүйн зөвлөлтэй бөгөөд үүнд 652 (эрэгтэй 118 буюу 18.1%, эмэгтэй 534 буюу 81.9%) албан хаагч ЁЗ3-д ажиллаж байна. Бусад байгууллага нь албан хаагчдын тооноос шалтгаалан ёс зүйн зөвлөл байгуулаагүй. Тайлант хугацаанд ёс зүйн зөрчилтэй холбоотой 21 өргөдөл гомдол ирснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу 100% шийдвэрлэж, 5 албан хаагчид уучлал гуйх, 9 албан хаагчид сануулах ёс зүйн хариуцлага хүлээлгэжээ. Бусад зөрчилд сахилгын хариуцлага тооцсон. Ёс зүйн зөрчилд холбогдсон албан хаагчдаас 1 нь ТЗ, 20 нь ТҮ-ний албан хаагч байна.



1.6. Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар нөлөөллийн 17 саналыг боловсруулж ТА3-д хүргүүлэв.


1.7. 2022 оны эхний хагас жилийн байдлаар 156 байгууллага 4248 албан хаагчийг улс, аймгийн хэмжээнд зохион байгуулсан сургалтад хамруулжээ.

Сургалт	Хамрагдсан ТАХ-чдын тоо	Үүнээс:	
		Эрэгтэй	Эмэгтэй
Зорилтод (ЗГ)	123	33 (26.82%)	90 (73.17%)
Арга зүйн (ТАЗ)	1401	435 (31.04%)	966 (68.95%)
Мэргэжил, арга зүйн (Аймаг)	2724	535 (19.64%)	966 (80.35%)

1.8. “Шинэ ажилтныг туршилтын хугацаанд чиглүүлэх хөтөлбөр”-т 54 албан хаагчийг хамруулан дадлагажуулсан байна.

1.9. Төрийн захиргааны болон үйлчилгээний 207 байгууллагаас 202 буюу 97.58% нь тайланд хамрагдсан бөгөөд нийгмийн баталгааг хангах чиглэлээр 2.0 тэр бум, ажиллах нөхцөлийг сайжруулах чиглэлээр 1.3 тэр бум төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байна.

1.10. Тайлант хугацаанд төрийн одон медалиар 36, салбар шагналаар 202, аймгийн шагналаар 153, байгууллагын шагналаар 239 албан хаагч шагнагдаж үйл ажиллагааныхаа үр дүнг үнэлүүлсэн байна. Салбар зөвлөлөөс 2 албан хаагчийг “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнуулах саналыг ТА3-д уламжилсан.




1.11. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны тогтоолоор “Төрийн албаны өдөр” тохиолдуулан Төрийн албаны тухай хуулийн 22, 23, 26, 27 дугаар зүйлд тавигдсан шаардлага нөхцөл болзлыг хангаж,



төрийн албаны тусгай шалгалтад тэнцэн улмаар тухайн албан тушаалд туршилтын хугацаанд ажиллахдаа төрийн албаны эрхэм зорилго, зорилт, чиг үүргийг мэргэжил, ур чадварын зохих түвшинд амжилттай гүйцэтгэж байгаа 41 албан хаагчаар "ТЗАХ-ийн тангараг өргүүлэх" ёслолын ажиллагааг Салбар зөвлөлийн 2022 оны 45 дугаар тогтоолын дагуу Зуунмод хотод зохион байгууллаа.

Мөн аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг даргын шийдвэрээр хариуцсан салбарын хөгжилд тодорхой ажлын амжилт, үр дүн гаргасан 11 албан хаагчийг аймгийн шагналаар шагнаж урамшуулсан юм.

1.12. Салбар зөвлөлөөс эрх хэмжээний хүрээнд 53 тогтоол гаргасан бөгөөд дундажаар 91.88%-ийн биелэлттэй байна.



1.13. Салбар зөвлөлд ирсэн хариутай бичиг, өргөдөл гомдол, СЗ-өөс явуулсан хариутай бичгийн шийдвэрлэлтийг танилцуулбал:


№	Төрөл	Нийт тоо	Үүнээс хариутай	Шийдвэрлэсэн	Хүлээгдэж буй	Шийдвэрлэлтийн хувь
1	Ирсэн албан бичиг	90	123	111	12	90.24%
2	Ирсэн өргөдөл, гомдол	11		11	0	100%
3	Явсан албан бичиг	99	78	71	7	91.02%

1.14. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтүүдийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

2. Сургалт, мэдээллийн чиглэлээр:

2.1.Өссөн дүнгээр ТАЗ-ийн “7:4:10” цахим сургалтыг 24 удаа зохион байгуулахад холбогдох албан хаагчдыг хамруулсан.

2.2.НҮБ-ын “Төрийн албаны өдөр”-өөр ТЗУХ-ийн харьяа байгууллагуудтай хамтарсан өдөрлөг зохион байгуулж, “Салбар зөвлөлийн үйл ажиллагаа, гишүүдийн танилцуулга” бүхий видео мэдээллийг 536 иргэнд хүргэж, 5 албан хаагчид ганцаарчилсан зөвлөгөө өгөв.




2.3.MERIT төслийн хоёр жил тутамд зохион байгуулагддаг уламжлалт “Мэдлэг, туршлагаа хуваалцах нээлттэй хэлэлцүүлэг, уулзалт” 2022 оны 6-р сарын 15-17-ны өдрүүдэд болж, уг арга хэмжээг төслийн хамтрагч байгууллагуудын албан хаагчид өнгөрсөн хугацаанд хамтран



хэрэгжүүлсэн сургалт, арга хэмжээнээс олж авсан мэдлэг, туршлагаа солилцох, цаашид тогтвортой ашиглах боломж, стратегийг тодорхойлох зорилгоор зохион байгуулсан.


3. Сонгон шалгаруулалтын чиглэлээр:



3.1. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 2.6-д заасны дагуу төрийн захиргааны 198 (удирдах 13, гүйцэтгэх 185) сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 4 удаа зохион байгуулсан. Шалгалтын дүнгээр нийт зарлагдсан ажлын байрны 39.4% нь нөхөгдөх

боломжтой болж хамгийн өндөр оноотой 78 оролцогч (үүнээс эрэгтэй 22, эмэгтэй 56)-ийг тухайн албан тушаалд нэр дэвшүүлэн томилуулсан.

3.2. Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.11 дэх заалт, “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 2.3-т заасныг тус тус үндэслэн төрийн үйлчилгээний байгууллагын 12 удирдах албан тушаал (төсвийн шууд захирагч)-ын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг 3 удаа зохион байгуулсан. Шалгалтын дүнгээр нийт зарлагдсан ажлын байрны 50.0% нь нөхөгдөх боломжтой болж хамгийн өндөр оноотой 6 оролцогч (үүнээс эрэгтэй 1, эмэгтэй 5)-ийг тухайн албан тушаалд нэр дэвшүүлэн томилуулав.



ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВИЙН ХҮРЭЭНД:

2022 оны 06 дугаар сард аймгийн Үйлчилгээний нэгдсэн төвд Төрийн болон бизнесийн, дэмжих үйлчилгээний нийт **15** байгууллага **500 гаруй** төрлийн үйлчилгээг **5229** иргэнд, өдөрт дунджаар **250-300** иргэнд хүргэн үйлчилсэн.

Тус төв нь Засгийн газрын 149-р тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн систем /E-mongolia/- ийг нэвтрүүлсэн бөгөөд тус системээр дамжуулан 06 сард аймгийн хэмжээнд **1237** лавлагаа үйлчилгээг иргэдэд гарган өгч үйлчилсэн байгаагаас ҮНТөвийн операторуудаас **293** лавлагаа үйлчилгээ авсан.

Байгууллагын цахим мэдээллийн буланд байх ухаалаг дэлгэцүүдээр дамжуулан иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж байгаа бөгөөд газрын нэгдсэн систем болох www.egazar.gov.mn сайтаар дамжуулан нийт **81** иргэн газрын талаарх үйлчилгээ авсан бол Гэрэгэ киоскоор дамжуулан **36** иргэн машины татвар, торгууль төлөх, үүрэн телефоны нэгж авах зэрэг үйлчилгээ авсан.

Мөн энэ сард манай төвд Төрийн Захиргааны удирдлагын хэлтсийн нээлттэй өдөрлөг болж тус өдөрлөгийн үеэр И-монголиа үйлчилгээний талаар иргэдэд мэдээ мэдээлэл хийн 30 гаруй иргэдийн утсанд E-mongolia аппликейшн суулгаж өгч бүртгүүлэн шаардлагатай зөөвөр, зөвлөмжийг хүргэн, 23 иргэнд тоон гарын үсэг олгосон.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ХҮРЭЭНД:

Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 олон улсын стандартыг нэвтрүүлэх зорилгоор Онцгой байдлын газрын даргын А/11 дүгээр тушаал “Ажлын хэсэг томилох тухай”, Онцгой байдлын газрын даргын А/14 дүгээр тушаал “Чанарын менежментийн тогтолцооны хамрах хүрээг батлах тухай”, Онцгой байдлын газрын даргын А/15 дугаар тушаал “Онцгой байдлын газрын алсын хараа, эрхэм зорилго, чанарын бодлогыг батлах тухай” тус тус гарган баталгаажуулж, холбогдох баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдөр аудиторын магадланд орж хамгаалсан.

“Архи согтууруулах ундаатай холбоотой асуудлаас сэргийлэх нь” аяны төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг хангасан. Онцгой байдлын газрын алба хаагчдыг Мичиганы сорил оношлогооны тестэнд хамруулан холбогдох мэдээ тайланг Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Эрүүл чийрэг эр хүн”, “Эрүүл идэвхтэй амьдрал” арга хэмжээний төлөвлөгөө, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу зохион байгуулагдах “Эрүүл мэндийнхээ төлөө-алхангаа ярилцъя” арга хэмжээнд Онцгой байдлын газрын “Алхалтын клуб”-ын гишүүд хамрагдсан.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Журам батлах тухай” А/139 дүгээр тушаалаар батлагдсан хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдах алба хаагчдын судалгааг насны бүлгээр гарган Эрүүл мэндийн газарт хүргүүлэн аймгийн нэгдсэн эмнэлгийн Дэмжих төвд 18-30 насны 28 алба хаагч шинжилгээ, үзлэгт бүрэн хамрагдан, 31-45, 45-60, 60-с дээш насны алба хаагчид шинжилгээ, үзлэгт хамрагдав.

Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулсан Нохой хөтлөгчийн давтан сургалтанд 1 алба хаагч 45 хоног хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүллээ. Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүрийн Пүрэв гарагт зохион байгуулагддаг цахим сургалтад давхардсан тоогоор 12 алба хаагч, хаагчийг хамруулсан.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан нэгдсэн хуваарь, удирдамжийн хүрээнд Их, дээд сургууль, коллеж ЕБС-ын оюутан сурагчдын дотуур байруудад Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагч бүрэлдэхүүнтэйгээр хяналт шалгалт зохион байгуулсан.

Шалгалтанд Төв аймгийн Зуунмод сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа их, дээд сургууль, коллеж ЕБС-ын оюутан сурагчдын дотуур байр нийт 3 байгууллага хамрагдахаас 3 байгууллага хамрагдаж гал түймэр гамшиг ослын аюулд хүргэж болзошгүй зөрчил 21 илэрснээс газар дээр нь 7 зөрчлийг арилгуулж 14 зөрчилд хугацаат үүрэг даалгавар гамшгаас хамгаалах болон гал түймрийн байцаагчийн албан шаардлага 3-г бичиж тухайн байгууллагуудын холбогдох албан тушаалтад хүргүүлэн, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах талаар зөвлөн туслах арга хэмжээг зохион явуулсан.

Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар Зуунмод сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа шатахуун түгээх станцын барилга байгууламжид хяналт шалгалтыг Гал түймрийн улсын хяналтын байцаагч, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч нар зохион байгуулсан. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар нийт 32 байгууллага, аж ахуй нэгжийг шалгаж гамшиг осол болон гал түймэр гарч болзошгүй 168 зөрчил дутагдлыг илрүүлж газар дээр нь 71 зөрчил арилгуулан холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын, албан тушаалтанд заавар зөвлөгөөг өглөө. Хяналт шалгалтад хамрагдаж, галын аюулгүй байдал нь

хангагдсан 18 аж ахуй нэгж байгууллагад ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт, 1 зөвшөөрөл олгов.

Онцгой байдлын газрын урьдчилан сэргийлэх тасгийн алба хаагчид, мэргэжилтэн нартай хамтран ангиллын сургалтыг танхим болон дадлага хэлбэрээр нийт 5 удаагийн 10 цагийн сургалтаар 125 ажилтныг хамруулсан. Батсүмбэр сумын Ахмад настны үндэсний төвийн 87 иргэнд /48 эрэгтэй, 39 эмэгтэй/ гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах бэлэн байдлаа хангах чиглэлээр 8 цагийн танхимын сургалтыг зохион байгуулсан.

Орон нутгийн ТBS телевизээр цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн үед хол замд зорчихгүй байх, бэлтгэл бэлэн байдлаа сайтар хангах, дулаан хувцаслах, баталгаат зам гүүр, маршрутаар явах, Онцгой байдлын байгууллагаас өгч буй заавар зөвлөмжийг хэрэгжүүлэх сэрэмжлүүлэг мэдээллийг цаг тухай бүр телевизээр дамжуулан ард иргэдэд өдрийн 2 удаагийн давтамжтайгаар нийт 54 удаа хүргэсэн.

Онцгой байдлын газрын 5200 дагагчтай фейсбүүк хуудсанд 13 удаагийн мэдээ мэдээлэл байршуулж, веб сайтад сэрэмжлүүлэг мэдээг 3 удаа, иргэдэд чиглэсэн зөвлөгөө зөвлөмжийг 5 удаа, байгууллагын үйл ажиллагаа, сургалт, хяналт шалгалт явуулсан талаарх мэдээ мэдээллийг 4 удаа нийт 12 удаагийн мэдээлэл байршуулж иргэдийг мэдээллээр хангасан.

Эрэн хайх аврах салбарын уснаас эрэн хайх завьний сэнс хугарсан байсныг Оросын холбооны улсруу захиалж бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллаа. Тусгай дуут дохио ашигладаг 14-н тээврийн хэрэгслийн мэдээллийг бэлтгэн цагдаагийн ерөнхий газрын бүртгэл хяналтын төвд хүргүүлж, тусгай шаардлага хангасан 7 тээврийн хэрэгсэлд тусгай дуут дохио ашиглах зөвшөөрөл олгуулсан. Төв аймгийн Заамар сумын Топ ган дринлинг ХХК-ын алтны шороон ордны гамшгийн эрсдэлийн үнэлгээг хүлээн авч, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны А/255 дугаар тушаалын дагуу анхан шатны дүн шинжилгээ хийж, Онцгой байдлын ерөнхий газрын гамшгийн эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлсэн.

Баянжаргалан сумын Жаргалант 1-р багийн нутаг дэвсгэрт нутаглаж буй малчин Г.Адъяагийн тусгаарласан 10 хонь үүнээс 2 эр, 1 эм нийт 3 хониноос ийлдэс, эд, арчдасын УМЭАЦТЛ-т хүргүүлж 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 22-2320 дугаар шинжилгээний дүнгийн цэцэг өвчин болох нь тогтоогдсон. Баянжаргалан сумын Засаг даргын 2022.06.23-ны А/90 тоот захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоосон. 2022 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар нийт 62 мал өвчилснөөс шинж тэмдэг арилсан-13, устгасан-6, ариутгал халдваргүйжүүлэлт хийгдсэн 3700м2 малын хашаа, 2500м2 бэлчээр, устгалын цэгийн 20м2 нийт 6220 м2 талбайд халдваргүйжүүлэлт хийсэн.

Эрэн хайх ажиллагааны 4 дуудлага /Баянчандмань, Эрдэнэ, Заамар/ мэдээлэл бүртгэгдсэн. Үүнээс төөрсөн-2, усанд осолдсон-2 дуудлагаар Онцгой байдлын газраас 14 алба хаагч, 1 эрэлч нохой, 3 автомашинтай, сум орон нутгаас 147 хүн, 18 иргэн морьтой нийт 165 хүн, 10 автомашин ажилласан.

Гал түймрийн нөхцөл байдал: Объектын гал түймрийн 5 /Баянжаргалан, Бүрэн, Баян-Өнжүүл, Батсүмбэр, Эрдэнэсант/ дуудлага мэдээлэл бүртгэгдсэн. Уг гал түймрийг унтраахад орон нутгаас 73 иргэн, 15 автомашинтай ажилласан.

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Газрын даргын тушаалаар батлагдсан хуваарийн дагуу /ковид-19/ халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд автотээврийн шалган нэвтрүүлэх цэг, худалдаа үйлчилгээний газрууд, ариутгал халдваргүйтгэлийн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагын “Хяналт удирдлагын нэгдсэн систем”-д БОДБХХХ-ийн хяналтын 9 чиглэлээр 10144 аж ахуйн нэгжийг эрсдэлийг үнэлж оруулсан.

Төв аймгийн нутаг дэвсгэрт газар эзмшигч ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч, мал эмнэлэг, сургууль цэцэрлэг зэрэг нийт 9 аж ахуйн нэгж, байгууллагад улсын байцаагчийн хамтарсан зөвлөмж хүргүүлсэн.

Зуунмод сумын Номт вилла хотхоны оршин суугчдаас ирүүлсэн өргөдлийн дагуу аймгийн Номт 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт гүйцэтгэж буй 90 айлын орон сууцны барилгын угсралтын ажилд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчилд улсын байцаагчийн хамтарсан 9 заалт бүхий албан шаардлага хүргүүлсэн. Баянчандмань сумын нутагт улсын чанартай автозамын ажил гүйцэтгэж буй “Арж Капитал” ХХК-д газрын хэвлийг дур мэдэн ашигласан үндэслэлээр 1500000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан. Дээрх хэргээс “Даблю Экс Пи” ХХК-д холбогдох хэргийг тусгаарлан Зөрчлийн хэрэг нээж мөн газрын хэвлийг дур мэдэн ашигласан үндэслэлээр 1500000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан.

Улаанбаатар-Дархан чиглэлийн хатуу хучилттай авто замын ажил хийж буй “Арж капитал”, “WXP” ХХК-ийн Баян-Чандмань сумын нутагт байрлах карьерийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан 15 заалт бүхий хугацаатай 2 албан шаардлага хүргүүлсэн.

Төв аймгийн Алтанбулаг сумын Бургасан сүүл гэх газар тарвага агнасан гэх иргэн Б.Мөнхчулуун, Төв аймгийн Лүн сумын 1-р багийн Монгол элс гэх газраас зөвшөөрөлгүй ногоон арц түүж бэлтгэсэн иргэн Н.Мөнхбаатар, Т.Энхтулга, Д.Балжинням нарт Зөрчлийн тухай хуульд заасны дагуу торгуулийн арга хэмжээ, Бугын эвэр худалдаж авсан гэх иргэн Д.Нямцогт, Т.Сүхтөмөр нарт зөрчлийн хэрэг нээж хэрэг бүртгэлтийн ажиллагаа явагдаж байна.

Баянчандмань сумын нутаг Шарын ам гэх газраас иргэн Б.Ганбат нь түлээний мод бэлтгэх эрхийн бичгээр 3 метр куб хэрэглээний мод бэлтгэж тээвэрлэсэн, Төв аймгийн Батсүмбэр сумын Баянгол 3 дугаар багийн нутаг Сөгнөгөрийн ам гэх газраас иргэн М.Гантөмөр нь 4 метр куб шинэс модыг эрхийн бичгээсээ хэтрүүлэн тээвэрлэсэн гэх зөрчилд зөрчлийн хэрэг нээн зөрчил шалган шийдвэрлэсэн.

Чингэлтэй, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэр бүхий 4 иргэний Ойн санд учруулсан хохирол 4.113.000 төгрөгийн нөхөн төлбөрийг гаргуулахаар нэхэмжлэл гаргасан. Сэргэлэн суманд үйл ажиллагаа явуулж буй Ананд биотехнологи ХХК-н үйл ажиллагаанд шалгалт хийж улсын байцаагчийн актаар үйл ажиллагааг нь зогсоосон.

Химийн бодисын агуулахын ажлын байранд дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн Эбаш, Агро би эй вая ХХК-уудын хүсэлтийн дагуу баталгаажуулах хяналт шалгалтыг хийж 19-04-014/17, 19-04-014/43 дугаартай улсын байцаагчийн хамтарсан дүгнэлийг гаргасан.

Төв аймгийн 27 сумдын их, богино сунгаа, бүсийн хурдан морин уралдаанаар барианы газарт асар байрлуулан сумдын ЗДТГ-ын мэргэжилтнүүд ажиллаж, бүртгэлийн үеэр уралдаанч хүүхдийн асран хамгаалагч, уяач, зохион байгуулагч нарт 300 гаруй гарын авлагыг тараан зөвлөгөө өгч, хүүхэд бүрийн гэнэтийн ослын даатгалд даатгуулсан. Аймаг, сумдын баяр наадмын комисс болон бүсийн морин уралдааны комисст 10 заалттай 32 зөвлөмж хүргүүлсэн.

Жаргалант суманд Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Тэнхун ХХК-д гарсан 1 үйлдвэрлэлийн осол 2 осолдогч, Сэргэлэн суманд үйл ажиллагаа эрхэлдэг Таван толгой ХХК-д гарсан 1 үйлдвэрлэлийн осол 2 осолдогчийн мэдээллийг МХЕГ-ын холбогдох газрын дарга, ахлах байцаагч нарт яаралтай мэдээлэх хуудсаар болон цахим хаягаар хүргүүлэн, ослын актыг хянаж байна.

Баянчандмань, Батсүмбэр, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Баянцогт, Зуунмод сумын нийт 10 шинээр баригдаж байгаа барилгад хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтын чиглэлээр хяналт шалгалт хийж мэргэжил арга зүйн зөвлөмж, зөвлөгөө өгч, 1 ААН-д албан шаардлага өгсөн.

Төв аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 19 аж ахуйн нэгж байгуулагад хамтарсан зөвлөмж, 2 аж ахуйн нэгж байгууллагад зөвлөмж хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд цацрагийн дэвсгэр түвшинд хяналт шинжилгээ хийх, Дулааны цахилгаан станц, нам даралтын зуухнаас гарч буй хаягдал үнсэнд хяналт шинжилгээ хийх, цацрагтай ажиллагчдын мэргэжлийн шарлагын хувийн тунд хяналт шинжилгээ хийсэн. Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран Төв аймгийн нэгдсэн эмнэлэгт төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, хамтарсан зөвлөмж өгч ажилласан.

Нийгмийн даатгалын салбарын хууль, тогтоомжийн биелэлтийг хангах, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагыг дээшлүүлэн ажиллах талаар аймгийн 14 аж ахуйн нэгж байгууллагад улсын байцаагчийн хамтарсан зөвлөмж хүргүүлсэн.

Зуунмод, Батсүмбэр, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Баянчандмань сумдын ашиглагдаж байгаа болон шинээр баригдаж буй барилгын аюулгүй ажиллагаанд хяналт шалгалт хийсэн.

Баталгаажуулалтын хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд Эрдэнэсант сумын сургуулийн хуучин дотуур байр, цагдаагийн байр, Батсүмбэр сумын Цагдаагийн кабон, Зуунмод сумын Төв чандмань ДЭХГ-ын харьяа Цэвэрлэх байгууламжийн барилга байгууламжуудад шалгалт хийж, барилгын ашиглалтын төлөв байдлын тухай дүгнэлт, хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай улсын байцаагчийн дүгнэлт, албан шаардлага, ашиглалтыг зогсоох тухай акт хүргүүлсэн.

Зуунмод суманд шинээр баригдаж байгаа 3, Жаргалант 1, Борнуур 1 барилгын дотор, гадна холбооны шугам сүлжээг холбогдох техникийн нөхцөл, зургийн дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж хамтарсан албан шаардлага-12, бие даасан албан шаардлага-1 хүргүүлсэн.

Баянжаргалан сумын Эрдэнэ 3-р багийн нутаг “Буурын ухаа” гэдэг газар оторлож яваа Дундговь аймгийн уугуул А, Т нарын малаас хонины цэцэг өвчин шинжилгээний дүнгээр батлагдаж тус сумын Засаг даргын А/90 тоот захирамжаар хорио цээр дэглэм тогтоосон. Малчин А-гийнх 1800 бог малаас 4 толгой хонийг устгаж, 57 хонийг тусгаарласан, Т-гийнх 2200 бог малтай 1 хонийг тусгаарласан байна. Тус бүс нутагт нутаглаж байгаа уяачдад хонины цэцэг өвчний талаар мэдээлэл өгч, голомтын бүсэд малын шилжилт хөдөлгөөн хийхгүй байх, халдваргүйтгэлийг тогтмол хийлгэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

Голомтын 2 өрх, сэжигтэй бүсийн 2 өрхөд нийт 6800 толгой малыг хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд хамруулсан.

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад Төв аймгийн Баяндэлгэр, Эрдэнэ, Сэргэлэн, Лүн, Алтанбулаг, Аргалант, Эрдэнэсант сумдын мах хадгалах, экспортлох, мал төхөөрөх, дулааны аргаар мах боловсруулах эрх бүхий 12 аж ахуйн нэгж иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан.

Баяндэлгэр хүнс ХХК, Сэргэлэн сумын Б.Наранцэцэгийн мал төхөөрөх цех, Лүн сумын Б.Баясгалангийн мал төхөөрөх цех, Аргалант сумын Г.Мөнхжаргалын мал төхөөрөх цехийн үйл ажиллагааг улсын байцаагчийн хамтарсан 4 актаар зөрчлийг арилгах хүртэл түр хугацаагаар үйл ажиллагааг нь зогсоосон.

Эрдэнэ хүнс ХХК, Аривжих лотос ХХК, Цоохор мандал ХХК-д илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан 45 заалттай 3 албан шаардлагаар хугацаатай

үүрэг даалгавар өгсөн. Сүлд цагаан уул ХХК-ний мал төхөөрөх цехэд улсын байцаагчийн хамтарсан зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

Дулааны аргаар мах боловсруулах 3, мал төхөөрөх үйлдвэр 3, мал төхөөрөх цех 5, нийт 4 аж ахуйн нэгж, 1 хоршоо, 4 иргэний 11 объектод хяналтын 6 чиглэлээр төлөвлөгөөт бус шалгалтад 37 хүнийг хамруулан /малын эмч-6, технологич-4, үйлдвэрийн дарга-11, бусад-16/ мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулж ажилласан.

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад Зуунмод сумын хүнсний худалдааны 61, хоол үйлдвэрлэлийн 21, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 9, өргөтгөсөн худалдааны үеэр хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй 5 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан. Хяналт шалгалтын явцад 178 зөрчил, дутагдал илрүүлж, 126 буюу 70.7%-ийг газар дээр нь арилгуулж хадгалалтын хугацаа дууссан 14 нэр төрлийн, 57 ширхэг 154.7 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг дотоод хяналтаар газар дээр нь устгуулсан.

Зуунмод сумын нийтийн хоол үйлдвэрлэл, хүнсний худалдаа, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 92 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хоол хүнсээр дамжих өвчин болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар 92 улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлсэн. Өргөтгөсөн худалдааны үеэр хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулах иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүнсний аюулгүй байдлыг хангуулах талаар Зуунмод сумын Засаг даргад 54 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

Хоол, хүнсний бүтээгдэхүүнээс гаралтай хордлого, хордлогот халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор улсын байцаагчийн 4 төрлийн зөвлөмж, байгууллагын цахим хуудсаар дамжуулан 3 төрлийн постер, 1 сэрэмжлүүлэг, хяналт шалгалтын явцын мэдээллийг олон нийтэд сурталчилсан.

13 суманд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, сумдын Засаг дарга нарт улсын байцаагчийн хамтарсан албан шаардлага, зөвлөмж хүргүүлсэн. 3 аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүнээс дээж авч аймгийн итгэмжлэгдсэн лабораторид 5 үзүүлэлтээр шинжилгээнд хамруулан улсын байцаагчийн зөвлөмж гаргасан.

Эрүүл ахуй нян судлалын лаборатори нь 106 дээжинд 278 үзүүлэлт /Гурил гурилан бүтээгдэхүүнд 1 сорьцонд 5, Хоолны 14 сорьцонд 58, төрөл бүрийн будаа 1 сорьцонд 1, сүүн бүтээгдэхүүн /зайрмаг/ 1 сорьцонд 4, гоо сайханы бүтээгдэхүүний 5 сорьцонд 30, гүний усны 19 сорьцонд 57, төвлөрсөн системийн ус 4 сорьцонд 12, Арчдас 48 сорьцонд 48, Хөрс 12 сорьцонд 60, Гемодиализын ус 1 сорьцонд 3/ үзүүлэлтээр эрүүл ахуй нян судлалын шинжилгээг хийж хянаж, баталгаажуулсан.

Эрүүл ахуй химийн лаборатори нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд нийт 9 сорьцонд 47 үзүүлэлтээр /гурил гурилан бүтээгдэхүүний 1 сорьцонд 3 үзүүлэлтээр, төмс хүнсний ногооны 4 дээжинд 8 үзүүлэлтээр гүний усны 4 дээжинд 36 үзүүлэлтээр/ эрүүл ахуй химийн шинжилгээг хийж хянаж, баталгаажуулсан.

Нэгж лабораториудад 106 сорьцонд 278 үзүүлэлтээр шинжилгээг хийж хянан баталгаажуулсан.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:

Авлигатай тэмцэх газраас төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх чиг үүргийн дагуу Шударга байдлын үнэлгээний судалгаа, мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулж 65 албан хаагч, шинжээч хамрагдсан.

Авлигатай тэмцэх газраас Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын дунд "Шударга ёсны хичээлийн хөтөлбөр" шалгаруулах уралдаанд Зуунмод сумын 5 дугаар сургуулийн бага ангийн заах аргын нэгдлийн багш нар шалгарлаа.

Засгийн газрын 2022 оны 194 дүгээр тогтоолоор төрийн захиргааны зарим албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл өөрчлөгдсөнтэй холбогдуулан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулж томилгоо хийх, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг хянуулж хуулийн шаардлагыг хангуулах чиглэлээр сумын Засаг даргын Тамгын газрын дарга, авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангах эрх бүхий албан тушаалтнуудад чиглэл өгч хэрэгжилтийг хангаж ажиллав.

Цагдаагийн Ерөнхий газраас зам тээврийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор "Аажуу явбал аяндаа хүрнэ дээ" нэгдсэн арга хэмжээг орон даяар эхлүүлж энэхүү арга хэмжээнд аймгийн төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагууд нэгдэж, нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа. Аян үеэр Цагдаагийн газарт хамгаалалтын түмбэ, согтуурал хэмжигч багаж, энгэрийн камер зэрэг 6.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өглөө.

Төрийн архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын хурлыг зохион байгуулж 23 байгууллагын байнга, түр, 70 жил хадгалах баримтын бүртгэлийг хэлэлцэн 6 байгууллагын бүртгэлийг баталж, 17 байгууллагад зөвлөмж өглөө. Борнуур, Сүмбэр, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагууд болон Зуунмод сумын 6 багийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд зөвлөн тусалж хугацаатай үүрэг чиглэл өгч ажиллав.

"Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлд танилцуулах мэдээ, танилцуулах тойм мэдээ, гадаад улсын төлөөлөгчидтэй уулзсан уулзалт, ярианы тэмдэглэл, гэрээ, хэлэлцээр, санамж бичгийн талаарх мэдээ болон тайлан, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2019-2021 онд өгсөн үүрэг чиглэлийг 91.39 хувьтай хэрэгжүүлж, Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн Ажлын албанд хүргүүлээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан 2022 оны хамтран ажиллах гэрээг хагас жилийн байдлаар 88.57 хувьтай хэрэгжүүлж тайланг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Х.Мөнхзулаар ахлуулсан Ажлын хэсэг Төв аймагт ажиллаж аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга болон хэлтэс агентлагуудын удирдлагуудад "Жендэр ба хүний эрх" сэдэвт сургалтыг 06 дугаар сарын 21-нээс 22-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус ажлын хэсэг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газарт ажиллаж Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн байдлыг шалгаж, 2019 оны 01/54 тоот зөвлөмжийн хэрэгжилтийн явц, байдалтай танилцлаа. Мөн Татварын хэлтэс, Ус цаг, уур орчны шинжилгээний газарт хөдөлмөрлөх эрх, хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд хяналт, шалгалт, Төв аймаг дахь Цагдаагийн газрын харьяа түр хамгаалах байрны үйл ажиллагаанд зөвлөмж чиглэл өгч ажиллалаа.

Төв аймаг дахь Цагдаагийн газар 2022 онд дэвшүүлсэн зорилт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж, хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний тайлангийн хурал болон албан хаагчдын сахилга хариуцлагын дээшлүүлэх зөвлөгөөнийг зохион байгуулж олон нийтэд үйл ажиллагаагаа сурталчилсан.

Мансууруулах төрлийн ургамлын тархацыг бууруулах чиглэлээр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Төв аймаг дахь Цагдаагийн газартай хамтран 5 суманд "Устгал" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахаар орон нутгийн төсвөөс 8.2 сая төгрөгийг шийдвэрлүүлэн бэлтгэл ажлыг хангав.

Зуунмод суманд үйл ажиллагаа явуулдаг 9 барьцаалан зээлдүүлэх газар (ломбард)-ын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, гэрээ байгуулах замаар хэрэглэгчийн эрхийг хохироож зээлийн хүүг 5 хувиас 7 хувиар тооцож байсан зөрчлийг илрүүлж Шударга өрсөлдөөн Хэрэглэгчийн төлөө газрын Улсын ерөнхий байцаагчийн албан шаардлагыг хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын Агаарын замын боомт хариуцсан газраас аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран Гадаадын хөрөнгө оруулалттай болон гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, хувийн хэргээр оршин сууж буй гадаадын иргэдэд холбогдох хууль тогтоомж, байгууллагаас үзүүлж буй цахим үйлчилгээг сурталчлан таниулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх зорилгоор “Хууль тогтоомж болон байгууллагаас үзүүлж буй цахим үйлчилгээг сурталчлах өдөрлөг”-ийг 13 аж ахуйн нэгж, байгууллагын 18 төлөөлөл, хувийн хэргээр оршин сууж буй гадаадын иргэн 2 нийт 20 хүнийг оролцуулан уулзалт, арга хэмжээг зохион байгууллаа. Аймгийн нутаг дэвсгэрт албан болон хувийн хэргээр нийт 13 улсын 234 гадаадын иргэн үүнээс хөдөлмөр эрхэлж буй 186, хувийн хэргээр 5, гэр бүлийн шалтгаанаар 11, түр ирэгч 2, хөрөнгө оруулагч 11, геологи, уул уурхайн салбарт 117, үйлдвэрлэл үйлчилгээний салбарт 39 гадаадын иргэн оршин сууж байгаа бүртгэл мэдээллийг гаргаад байна.

ТӨРИЙН АРХИВЫН ТАЛААР:

Төрийн архивын эх баримтаас байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 146 иргэний хүсэлтийг хүлээн авч 867 хуулбар хувь, 111 лавлагаа, 177 сан хөмрөгийн 648 хадгаламжийн нэгжийн баримтыг ашиглан үйлчилгээ үзүүлэв. 3 хөмрөгийн 32 хадгаламжийн нэгжийн 4371 хуудас баримтын 18070 хүний нэрийг скайнердаж программд оруулав.

Төрийн архивт нөхөн бүрдүүлэлтээр Виллвест” ХХК “ТТИ “ХХК Сэргэлэн сумын гадна цахилгаан хангамжийн 2, Бат цариг” ХХК иргэн Ш.Баясгалангийн Фермерийн гадна цахилгаан хангамжийн 2, Тэнгэр Уул” констракшн Баянчандмань сумын С.Зоригийн гадна цахилгаан хангамжийн 2, Мэнхэн тахилга” ХХК Эрдэнэ сумын 1-р багийн иргэн Ц.Баяраагийн гадна цахилгаан хангамжийн 2 нийт 8 хадгаламжийн нэгжийг тус тус хүлээн авч, хадгаламжийн санд бүртгэж авлаа.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр цахим санд нийт 63.036 хувийн хэрэг байгаагаас газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 138.200 газар өмчлөх эрхийн 51.567 байна. 6 дугаар сард хүлээн авсан мэдүүлэг-1576 байна.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 230 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос нийт 25,315,231 төгрөг, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны 155,955,628 төгрөг, тэмдэгтийн хураамжаас 4,841,360 төгрөгийг улсын төсөвт орууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 64 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлснээс 38 нэмэлт өөрчлөлт, шинээр 26 хуулийн этгээд үүсэн байгуулагдаж татан буугдсан хуулийн этгээд 2, үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 17 бүртгэл хийгдсэн. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 2 лавлагаа, хууль хяналтын байгууллагад 17 лавлагаа өгч 11,750,0 төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа.

ЦАГДААГИЙН ГАЗРЫН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 356 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 138 хэргээр буюу 63,3 хувиар өссөн, гэмт хэргийн илрүүлэлт 43,8 хувьтай, өмнөх оны мөн үеэс 5 хувиар өссөн байна.

Гудамж талбай, олон нийтийн газар, ахуйн хүрээндээ архидан согтуурч бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж, жижгээр танхайрсан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, өөрийгөө удирдан биеэ авч явах чадваргүй зэрэг зөрчил гаргасан 58 иргэнийг саатуулж, эрүүлжүүлсэн-12, Төв аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 7-30 хоногийн хугацаагаар баривчлагдсан-48 иргэнийг эрүүл мэндийн үзлэг хамрууллаа.

2022 оны 05 дугаар сарын 25-наас 06 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон 152 жолоочийг илрүүлж, 116 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасч, 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэж тээврийн хэрэгсэл жолоодон хөдөлгөөнд оролцсон 36 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулж Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн санд мэдээллийг бүртгэв. Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 4235 жолоочийг 101.8 сая төгрөгийн торгууль оногдуулж, зөрчил гаргасан 95 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатуулан ажиллалаа.

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Криминалистикийн шинжилгээ-104, магадлан шинжилгээ-127, хэргийн газрын үзлэгт оролцсон тоо-280, хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-762, гарын хээний санг дардсаар баяжуулсан-449, мөрөөр баяжуулсан-59, гэмтлийн зэрэг тогтоосон дүгнэлт-379, ДНК-ийн мэдээллийн сангийн баяжилт-116, гистологийн шинжилгээ-127 тус тус хийгдлээ.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ЧИГЛЭЛЭЭР:

Бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
6-р сар	217	330	8	539	265	274	49.2
	4587209.8	1668867.6	165175.8	6090901.6	1959886.8	4131014.8	

ДӨРӨВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХҮРЭЭНД:

Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 4 зорилтын 21 арга хэмжээний хэрэгжилтийн явцын тайланг 2022 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 92.38 хувьтайгаар хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан (www.new.unelgee.gov.mn)-аар Засгийн газарт тайлагналаа.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн товчоо

Бүлэг	2022 оны эхний хагас жилийн байдлаар					
	Арга хэмжээ	Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Дундаж үнэлгээ
			100	70-100	30-70	0-30

Эдийн засгийн бодлого	8	7	1	-	-	96.25%
Засаглалын бодлого	4	3	-	1	-	87.25%
Ногоон хөгждийн бодлого	3	1	1	1	-	73.33%
Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	6	4	1	1	-	91.66%
Нийт	21	15	3	3	-	92.31%



Хэлтэс, агентлаг, харьяа байгууллага, сумдын үйл ажиллагааны явцад хийх **“Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийн удирдамж”-ийг** аймгийн Засаг даргын 2022 оны А/301, А/302 дугаар захирамжаар шинэчлэн батлуулж, удирдамжийн дагуу хэлтэс, агентлаг харьяа байгууллага болон сумдын Засаг даргын Тамгын газар төсөвт байгууллагын

үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж зөвлөн тусаллаа.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын чиглэлээр:

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны төлөвлөгөөний дагуу Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад аймгийн ЗДТГ, Санхүү төрийн сангийн хэлтэс, Засаг даргын тусгай сан, ОНХС, Төв Чандмань ДЭХГ-ын 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, Зуунмод сумын Бүжинхэн, Дэгдээхий, Ирээдүй, Унагалдайн андууд, Хүмүүн цэцэрлэгүүд, IV сургууль, V сургууль, Хүмүүн цогцолбор цэцэрлэг, Бумбардай цэцэрлэг, Зуунмод сумын ЗДТГ, ИТХ, Соёлын төв, Хот тохижуулах газар, Баруун Зуунмод ББН өрхийн ЭМТ, Архуст, Баян, Баянжаргалан, Баянцогт, Аргалант, Лүн, Баянхангай сумдын төсөвт байгууллагуудын 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, Баянцагаан сумын ЭМТ, Мөнгөнморьт сумын ЗДТГ, Татварын хэлтэс, ОНХ-ийн сан, ЭЭС, Сумдын сум хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, өргөдлөөр аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг тус тус хийж 5,419,527.0 төгрөгийн зөрчил илрүүлж 281,307.5 төгрөгийн зөрчилд улсын ахлах байцаагчийн акт, 1,951,229.8 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага, 3,186,989.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч ажиллав. Өмнөх оны актын үлдэгдэл 171,193.5 мянган төгрөгөөс 62,354.0 мянган төгрөг, 2022 онд тогтоосон актаас 81,173.2 мянган төгрөг тус тус барагдсан байна.

ТАВ. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХҮРЭЭНД:

Төсвийн орлогын талаар:

Орлогын төлөвлөгөө эхний 05-р сарын байдлаар орон нутаг 8774.2 сая төгрөг төвлөрүүлэхээс 9151.3 сая төгрөг төвлөрүүлж 104.3 хувьтай, 377.1 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө давж биелсэн байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 1629,7 сая төгрөг төвлөрүүлэхээс 3305,8 сая төгрөг төвлөрүүлж 202,8 хувьтай, 1676,1 сая төгрөгөөр давж биелсэн. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 2707,7 сая төгрөгөөр биелж, 121,6

%-тай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн 18 сум, 2 шатны орлогын төлөвлөгөө биелүүлсэн 19 сум байна.

2022 оны 5 сарын байдлаар нийт 14035,2 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг аймгийн төсөвт байгууллагууд болон 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

-Сумдын ИТХ,ЗДТГазрын санхүүжилтэд 7446,5 сая төгрөг

-Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 6588,7 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна

2022 оны 5-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгууллагууд нийт 152,5 сая төгрөгийн авлага, 478,5 сая төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 368,7 сая төгрөг буюу 77,0 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 24,0 сая төгрөг буюу 5,0 хувь нь гэрэл цахилгааны өр, 34,0 сая төгрөг буюу 7 хувь нь тээвэр шатахууны өглөг, үлдсэн 51,8 сая төгрөг буюу 11 хувийг бусад өр эзэлж байна

ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО,ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:

Хөрөнгө оруулалт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 59,469.7 сая төгрөгийн 96 төсөл, арга хэмжээг тусган баталж үүнээс тендер шалгаруулалт зохион байгуулахаар 59,314.7 сая төгрөгийн 85 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөсөн.

2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт оны эхний хагас жилийн байдлаар худалдан авах ажиллагааны явц дараах гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- *Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ:* Нийт 40,361.2 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээнээс УИХ-ын 2022 оны улсын төсөвт тодотгол баталсантай холбоотойгоор 701.5 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг бүрэн зогсоосон. Захиалагч байгууллагад 38,059.7 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээнд тендер шалгаруулалт явуулснаас 7 төсөл, арга хэмжээнд 36,475.4 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан. 900.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын үр дүнд гомдол гарч Сангийн Яаманд хянагдаж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдах Жаргалант сумын 150 ортой цэцэрлэгийн барилга угсралтын ажлын тендер 5 удаа зарласан боловч шаардлага хангасан оролцогч оролцоогүй дахин зарлахаар, мөн БОАЖЯамнаас эрх шилжүүлсэн 100.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг тус яамны сайдын 2022.05.11-ны өдрийн 01/2586 дугаар албан бичгийн дагуу шийдвэр гартал түр зогсоосон.
- *Аймгийн шилжих үлдээдлээс хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:* 2,507.0 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулахаас 12 төсөл, арга хэмжээнд 2,358.8 сая төгрөгийн гэрээ байгуулагдаж, 170.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ гэрээ байгуулагдах шатанд ажлын 6 хоног хүлээгдэж байна.
- *Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:* Замын сангаас 2,742.6 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээнээс Гэрээ байгуулсан -1, Үнэлгээ хийгдэж буй-1, Тендер зарласан-1, ажлын гүйцэтгэлтэй байна.
- *Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:* 2022 онд хэрэгжүүлэх нийт 3249.4 сая төгрөгийн 24 төсөл, арга хэмжээнээс 2542.8 сая, төгрөгийн 22 ажилд гэрээ байгуулагдаж, 178.0 сая төгрөгийн 2 ажилд гэрээ байгуулах шатанд ажлын 6 хоног хүлээж байна.

- *Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:* Нийт 1,206.9 сая, төгрөгийн 6 төсөл, арга хэмжээнд 100 хувь тендер зарлаж, 6 сард тендерийн нээлт хийх 283.0 сая, төгрөгийн 1 ажилд үнэлгээний хороо үнэлгээ хийж ажиллаж байна. Захиалагч байгууллагад 923.9 сая төгрөгийн 5 ажилд гэрээ байгуулах эрх олгосноос 5 ажилд 894.8 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан байна.
- *Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:* Нийт 608.0 сая, төгрөгийн 5 төсөл, арга хэмжээнд тендер зарлахаас гэрээ байгуулагдсан 244.0 сая, төгрөгийн 3 ажил, хэлэлцээр хийгдэж буй 300.0 сая төгрөгийн 1 ажил байна. Захиалагчийн шийдвэрээр 64.0 сая төгрөгийн 1 ажилд гэрээ байгуулагдсан.
- *Гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:* Япон улсын хөрөнгө оруулалтаар Хүмүүн цогцолбор сургуулийн барилгын дотор засварын ажлын тендерийг 2 дахь удаагаа зарлаж, нээлтийг 2022.07.18-нд зохион байгуулахаар ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн, Монгол Улсын Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэхэд манай аймгийн гүйцэтгэх үүрэг, цаашдын хөгжлийн чиглэл, хийгдэх их бүтээн байгуулалтыг сурталчилсан, Төв аймагт өрнөх “Шинэ Зуунмод хот”, “Эдийн засгийн чөлөөт бүс”, “Богд хаан төмөр зам” зэрэг их бүтээн байгуулалтыг сурталчлан таниулах, Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн стратеги төлөвлөлт, Зуунмод үйлдвэр технологийн паркийн хүрээнд хэрэгжих хөгжлийн төслүүд болон аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн бүтээн байгуулалтын ажилд төр, хувийн хэвшил, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог хангах, санал санаачилгыг өрнүүлэх хүрээнд хөрөнгө оруулагчдыг татах зорилготой “Шинэ сэргэлтийн бодлого-Хөгжлийн түүчээ-Төв аймаг” эдийн засгийн чуулганыг 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж, төрийн байгууллагын 110, төрийн бус байгууллагын 32, аж ахуйн нэгж байгууллага, хоршооны 140, гадаад 5 улс орны 12, нийт 300 орчим зочид, төлөөлөгчид оролцон чууллаа. Чуулганы үр дүнд 814.1 тэрбум төгрөгийн, 3000 гаруй ажлын байр бий болгох хамтын ажиллагааны гэрээ байгууллаа.

Эдийн засгийн чуулганы хүрээнд:

1. “Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх онгоцны буудал орчмын хот байгуулалтын асуудлууд, Зуунмод хотын хөгжлийн цаашдын чиг хандлага”,
2. “Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн стратеги төлөвлөлт, Үйлдвэр технологийн парк, түүний хүрээнд хэрэгжих төслүүд”
3. “Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ой” гэсэн үндсэн 3 салбар хуралдаан боллоо.

Чуулганы зорилго нь “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг аймаг, орон нутагтаа цаг алдалгүй үр дүнтэй хэрэгжүүлэх, аймгийнхаа хөгжлийн хязгаарлагч хүчин зүйлийг тодорхойлох, төсвийн үрэлгэн биш, үржүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, эдийн засгийг сууриар нь тэлэх бөгөөд чуулганы үр дүнд Төв аймгийн хөгжлийн шинэ гарцыг нээж, боломжуудыг баялаг болгох ажлыг төр, хувийн хэвшлийн идэвхтэй оролцоо, хамтын хүчин чармайлтаар хэрэгжүүлснээр ойрын 10 жилийн хугацаанд Эдийн засгийн өсөлт болон нэг хүнд ногдох орлогоороо бүс нутагтаа тэргүүлэх, өгөөжийг нь орон нутаг, иргэд нь хүртсэн аймаг болох явдал юм.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Барилга хот байгуулалтын сайд тэргүүтэй төлөөлөгчид 2022.06.09-нд Алтанбулаг суманд ажиллаж, “Сумын хөгжил: инженерийн дэд бүтцийн хангамж төсөл”-ийн хүрээнд иргэд олон нийттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, 2022.06.23-ны өдөр Баянчандмань, Борнуур сум, 2022.06.22-нд Дэлгэрхаан сумын “Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээний шав тавих арга хэмжээ болж, төслийн ажлыг эхлүүллээ.

Зураг төсөл боловсруулах, зөвшөөрөлцөх, магадлал хийх дүрмийн дагуу Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах баталгаажуулах ажлын хүрээнд нийт 2022 онд 44 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан баталсан ба энэ сард 11 архитектур төлөвлөлтийн даалгавар олгосон.

Зураг төсөл боловсруулах даалгавар нийт 45 боловсруулан баталсан. Энэ сард 11 зургийн даалгавар боловсруулан баталсан. Зураг төсөл зөвшөөрөлцөх баталгаажуулах, ерөнхий төлөвлөгөө батлах, ажлын хүрээнд 2022 онд 80 зураг төсөл зөвшөөрөлцсөн. Энэ сард 18 зураг төсөл батлаад байна.

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төсөл сонгон шалгаруулалт зарлан Багц 2 байршилд 1-р багийн хүнсний үйлдвэрийн 1, 2, БАМ-ын 31, 32, 33-р байр, 3, 4, 5, 15-р байрны байрны барилгажилтын төслийг шалгаруулах сонгон шалгаруулалтыг 2022.05.27-нд зарлан 2022.06.09-ний өдөр төсөл хүлээн авч, БАМ-ын 31, 32, 33-р байрны дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэхээр Алаг хайрхан бугат ХХК санал ирүүлсэн. Аймгийн Засаг даргын 2022.06.22-ны а/363 дугаар захирамжаар Алаг хайрхан бугат ХХК төсөл хэрэгжүүлэх эрхийг олгосон.

Барилга, инженерийн байгууламжийн зураглалыг шалгаж, хот байгуулалтын мэдээллийн санд 5 гүйцэтгэлийн зураг хүлээн авч акт олгосон.

Засгийн газрын 2021 оны 212, 213 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох болон ашиглалтад оруулах” дүрмийн хүрээнд Барилга эхлүүлэх зөвшөөрөл энэ онд нийт 44 барилга байгууламжид олгон энэ сард 18 барилга байгууламжид олгосон байна. Барилга ашиглалтад оруулах үйл ажиллагааны хүрээнд энэ онд нийт 25 барилга байгууламжийг ашиглалтад оруулсан ба энэ сард 4 барилга байгууламж ашиглалтад орууллаа.

ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу иргэнд 2022 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил зориулалтыг баталсан Засгийн газрын 2022 оны 121 дугаар тогтоолын хэрэгжилтийг ГЗБГЗЗГазарт цахимаар хүргүүлсэн. 2022 онд шинээр өмчлүүлэх 4709 иргэнд 1420,25 га, эзэмшиж буй газрыг өмчлүүлэх 931 иргэнд 65,06 га, улсын чанартай авто зам дагуу өмчлүүлэх 559 иргэнд 39,13 га, аж ахуйн зориулалтаар иргэнд үнээр нь өмчлүүлэх 1 иргэнд 0,1709 га, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнээр өмчлүүлэх 40 иргэнд 0,7 га газрыг төлөвлөснөөс шинээр өмчлүүлэх 221 иргэнд 40,02 га, эзэмшиж буй газрыг өмчлүүлэх 3 иргэнд 0,63 га, улсын чанартай авто зам дагуу өмчлүүлэх 4 иргэнд 0,38 га, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнээр өмчлүүлэх 3 иргэнд 0,04 га газрыг өмчлүүлсэн.

Аргалант сумын Нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын зардалд 30 сая төгрөг төсөвлөн гүйцэтгэгчээр Лапланд эко ХХК шалгаран гүйцэтгэж байна. Батсүмбэр, Баян сумд нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах ажлын тендерийг зарлаад байна.

“Төлөөлөгчийн өдөр-нээлттэй хаалганы өдөрлөг”-өөр Алтанбулаг, Лүн сумдад нээлттэй хаалганы өдөрлөгт оролцон Алтанбулаг суманд нийт 15 иргэнд мэдээллийн сангаар үйлчилж, Лүн суманд нийт 24 иргэнд мэдээллийн сангаар үйлчилсэн.

Газрын төлөв байдал чанарын захиалгат хянан баталгааны дүгнэлтийг Газрын мониторингийн цахим системээр хүлээн авч баталгаажуулан ажиллаж байна. 2022.06.30-ны байдлаар 134 мэдэгдэх хуудас хэвлэж өгсөнөөс 114 хянан баталгааг цахимаар ирүүлсэн байна.

Аймгийн нутаг дэвсгэрт газрын төлөв байдал чанарын захиалгат хянан баталгаа хийж байгаа тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагуудад заавар зөвлөгөөг өгч, шаардлага хангаагүй засварлах шаардлагатай 7 тайланг буцаан засвар хийлгэн цахим системээр баталгаажуулан ажиллав. Газрын төлбөрийн орлого 2022.06.30-ний байдлаар өссөн дүнгээр 1,03 тэрбум төгрөг аймаг, сумын төсөвт төвлөрүүлсэн.

Газрын цахим биржийн 100140000967 тоот дансанд газрын дуудлага худалдааны орлогоос өссөн дүнгээр 1.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн. 2022 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газрын цахим биржийн программаар Баян, Баян-Өнжүүл, Зуунмод, Бүрэн, Борнуур сумдын нийт 42 нэгж талбарт газрын дахин дуудлага худалдааг зарлан баталгаажуулсан. Мөн Баянхангай сумын 25 нэгж талбарт төсөл сонгон шалгаруулалтыг зарлан баталгаажуулсан.

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЧИГЛЭЛЭЭР

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын ажлыг эрчимжүүлэх чиглэлээр орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тооллогын ажлын гүйцэтгэлд ОНӨГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг Сэргэлэн сумын 5, Зуунмод сумын 11, Аймгийн ХААГ, ЦГ, ЭМГ, АНЭ, Аймгийн ЗДТГ зэрэг төсөвт байгууллагуудад түүвэрчлэн хяналтын тооллогыг нүд үзэн зохион байгуулсан. Тооллогоор бүртгэлгүй хөрөнгийг бүртгэлжүүлэх, дутагдуулсан хөрөнгийг илрүүлэн зөрчил дутагдлыг арилгуулахаар хугацаатай үүрэг чиглэл өгсөн. Эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын нэгдсэн программд нийт 33 байгууллага санхүүгийн тайлан, хөрөнгийн бүртгэл ирүүлснээс 4 байгууллагын тайланг баталгаажуулан, 29 байгууллагын тайланг засварлуулахаар буцаасан. Тооллоготой холбоотой 35 байгууллагын регистрийн дугаар холбогдох засварыг программын газарт хүргүүлэн засварлуулж хөрөнгийн мэдээллийг бүртгэх бэлтгэл ажлыг хангаж ажилласан.

Аймгийн “Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ыг хэрэгжүүлэн нийт 25 өрхийг түрээсийн орон сууцанд хамруулж, 2022 оны 06 сарын байдлаар 23 айлын түрээсийн төлбөр 17,416,015 төгрөг төвлөрүүлсэн байна.

ЗАМ ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Авто замын салбарын хүрээнд: Зуунмод-Хөшгийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлыг холбосон авто замын барилгын ажлыг 8161.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2021-2022 онд он дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Зам барилгын ажлын гүйцэтгэгчээр Анандын зам компани шалгаран гэрээ байгуулан ажлын гүйцэтгэл 30 хувьтай хэрэгжиж байна.

Зуунмод сумын Баянхошуу багийн чиглэлийн авто замын шинэчлэлийн ажлыг 500.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байна. Зам барилгын ажлын гүйцэтгэгчээр Шилдэг зам коспани шалгарч гэрээ байгуулан ажиллаж 70 хувийн хэрэгжилттэй байна.

Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох 122,4 км хатуу хучилттай автозам"-ын төслийн зам барилгын ажлыг эхлүүллээ. Мөн Зуунмод хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу 4,0 км үерийн байгууламжийн зураг төслийг Гидро ком байгууламж ХХК-р гүйцэтгүүлэн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэж байна.

БХБСайдын багцын хөрөнгө оруулалтаар Зуунмод, Баянхангай, Аргалант сумдад үерийн хамгаалалтын барилга байгууламжийн зураг төслийг боловсруулахаар 145.0 сая төгрөг батлагдан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах шатандаа байна.

Зуунмод сумын 5-р баг, Соёл амралтын хүрээлэн болон гэр хорооллын сууршлын бүсэд хөрсний ус зайлуулах байгууламжийн зураг төслийг боловсруулан 2022 онд 450.0 сая төгрөг батлагдан тендерт “Усны барилга” ХХК шалгаран гэрээ байгуулж, ажил эхэлсэн. Мөн сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл хэрэгжиж байгаа 14 сумдад төслийн хүрээнд үерийн уснаас хамгаалах далан сувгийг байгуулахаар зураг төсөл боловсрууллаа.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

2022-2023 оны Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах аймгийн төлөвлөгөөг Засаг даргын захирамжаар батлуулан, сумдад бэлтгэл ханган хэрэгжүүлэх ажиллах үүрэг чиглэл өгч ажиллаж байна. ХХААХҮЯ-ны МААБХЗГ-тай хамтран “Мал аж ахуйн нэгдсэн систем, түүний дэд сангууд ашиглах” цахим сургалтыг хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүд, малын үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжүүдийн 22 хүнийг хамруулан зохион байгуулж, программд ээмэгжүүлсэн малыг болон технологит ажлыг бүртгэх практик мэдлэг олголоо.

Шинэ хөдөө төслийн хүрээнд улсын төсвийн 180.0 сая төрөгийн хөрөнгөөр тал хээрийн сумдын үхрийг Герефорд, Сэлэнгэ үүлдрийн бухны үрээр зохиомол хээлтүүлэг хийх ажлын нээлттэй тендерт гүйцэтгэгчээр шалгарсан “Үржлийн шилмэл сүрэг” хоршоотой гэрээ байгуулж, ажлыг эхлүүллээ.

Баянцагаан, Алтанбулаг, Лүн, Эрдэнэсант сумын “Малчдын зөвлөгөөн”-д оролцож, Мал аж ахуйн салбарын бодлого хөтөлбөр болон мал үржүүлэг, малын тэжээл, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх боломж зэргээр мэдээлэл өгч, “Төл мал угтуулан тэжээх”, “Гар тэжээл, бэлтгэх аргачлал, зөвлөмж”, “Цахим урамшуулал” зэрэг гарын авлага тараах материалаар нийт 820 гаруй иргэдэд үйлчилгээ үзүүллээ.

Аймгийн Засаг даргын А/122 тоот захирамжаар Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1585.0 мян.тол мал хамруулахаар төлөвлөн Биокомбинат ТӨХХК-тай гэрээ байгуулан, эм биобэлдмэлийн татан авалт 88.6%, дархлаажуулалт 68.6 хувьтай явагдаж байна.

Баянжаргалан суманд хонины цэцэг өвчин оношлогдож халдварын хүрээг хумих зорилгоор 9200 хонийг дархлаажуулан 4300 м2 талбайд халдваргүйтгэл хийж, голомтод 2 малын эмч ажиллан хорио цээрийн дэглэм тогтоогоод байна.

Малын эрүүл мэндийн үзлэгт 4100.0 мян.тол мал хамруулахаас 1721.1 мян.тол мал хамруулж 41.4 хувьтай, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 7943.2 мян.тол мал хамруулахаас 2782.2 мян.тол мал хамруулсан 35.0 хувьтай, 1350 мян.м2 талбайд халдваргүйтгэл хийхээс 1115.6 мян.м2 талбай буюу 75.2 хувьтай тус тус хэрэгжиж байна.

Мал амьтан эрүүл мэндийн чиглэлээр “Гоц халдварт, халдварт өвчний үед дээж авах, оношлох шинжилгээний арга”, “Гоц халдварт өвчний эрт илрүүлэг, хариу арга хэмжээ болон оролцоот эпидемилогийн тандалт судалгаа” сэдэвт сургалтад 124 малын эмч, алба хаагчдыг хамруулан зохион байгууллаа.

МХГ, ЦГ, ТГ-тай хамтран 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр мал төхөөрөх үйлдвэр, цех болон мах дулааны аргаар боловсруулах 12 объектэд хяналт шалгалт хийж, 4 объектийн зөрчлийг арилгуулахаар үйл ажиллагааг нь түр зогсоосон.

2022 оны 06-р сарын байдлаар 7020 мал, амьтан, 95.3 тн мах, махан бүтээгдэхүүн, 501 ширхэг арьс шир, 1004.1 тн сүү, сүүн бүтээгдэхүүн, 5.5 тн ноолуур, 4 тн ноос, 453 кг дэл,

сүүл, 13.6 тн дайвар бүтээгдэхүүнд 1738 мал эмнэлгийн гэрчилгээг олгож, 59 дуудлагын дагуу 335 малд үйлчилгээ үзүүлээ.

Лүн суман дахь Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг нь 4 ээлжээр 24 цагт малын шилжилт хөдөлгөөн, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийж, мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэн явж байгаа 351 тээврийн хэрэгсэл, адуу 790, үхэр 425, хонь 6137, ямаа 766, тэмээ 9 нийт 8127 толгой мал, 13,5 мах, махан бүтээгдэхүүн, ноолуур 23.6 тн, сарлагийн хөөвөр 500 кг, арьс шир 59 ширхэг, дайвар 15.6 тн бүтээгдэхүүнд эрүүл ахуйн үзлэг хийн, мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт шалгалт хийж ажиллав.

Аймгийн хэмжээнд үр тариа 76239 га-д тариалахаас 58070 га буюу 76.2 хувь; төмс 9600 га-д тариалахаас 12441 га буюу 100 хувь; хүнсний ногоо 1649 га тариалахаас 1724 га буюу 100 хувь; тэжээлийн ургамал 30000 га-д тариалахаас 7079 га-д буюу 23.6 хувь; тосны ургамал 18250 га-д тариалахаас 24623 га буюу 100 хувиар хангаж, жимс, жимсгэнэ 10.7 га, олон наст ургамал 10 га нийт 104017 га-д тариалж, хаврын тариалалтын явц 84.72 хувьтай байна.

Хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэлд 4 суманд нийт 2356 мкв 4 өвлийн хүлэмж, 5 суманд 7194 мкв 46 зуны хүлэмж шинээр баригдаж, аймгийн хэмжээнд өвлийн хүлэмжийн талбай 90998 мкв, зуны хүлэмж 140167 мкв-д болж, хүлэмжийн талбай хэмжээ 231165 мкв-д хүрсэн.

ХХААХҮ-ийн судалгаа хөгжлийн төвтэй хамтран “Тариалангийн үйлдвэрлэлийн нэгдсэн систем-Хүнсний ногооны урамшуулал” сэдэвт сургалтыг Борнуур, Батсүмбэр сумдын 70 гаруй ногоочин, Тариалангийн үйлдвэрлэлийн нэгдсэн системийн цахим сургалтад 6 сумын газар тариалангийн мэргэжилтнүүдийг хамруулан, бүртгэлийн системийн талаар мэдээлэл өглөө. Тариаланчдад олгох 3% -ийн хөнгөлөлттэй зээлийн судалгааг нарийвчлан гаргаж, 3788 иргэн, ААН судалгааг авч, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Аймгийн “Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн стратеги төлөвлөлт”-ийн хүрээнд “Сүү бэлтгэн нийлүүлэгч хоршоодын тулгамдсан асуудал шийдэл” өдөрлөгийг Батсүмбэр сумын Цогт-Өндөр багийн төвд ШУТИС-ийн Бизнесийн ахисан түвшний сургууль, Тана лабортори, Жайка-Монгол ОУБ, Үйлдвэр технологийн паркийн холбоо ТББ, Сүү ХК зэрэг төр, хувийн хэвшил, шинжлэх ухааны байгууллага хамтран зохион байгуулсан. Тус өдөрлөгт Батсүмбэр, Баянчандмань, Борнуур сумдын 10 хоршооны 41 гишүүн, фермийн аж ахуй эрхлэгч нийт 80 гаруй иргэн, аж ахуйн нэгж оролцож “Японы дундын хоршооны бүтэц зохион байгуулалт”, “Хоршоодын өнөөгийн нөхцөл байдал”, “Үнээ болон өсвөр үхрийн зохистой тэжээл” сургалтад хамрагдаж, тулгамдаж буй асуудал шийдлийн хэлэлцүүлэг хийсний үр дүнд хоршоод хамтын ажиллагаа бэхжүүлэх нөхцөл бүрдсэн. Аймгийн хэмжээнд анхан шатны хоршоо 30, дундын хоршоо 8 байгуулагдав.

Сэргэлэн суманд байгуулах “Үйлдвэр технологийн парк” бүсд байгуулагдах мах, сүү бэлтгэлийн систем дэх “Хоршоо болон Паркийн үйлдвэрлэл-логистикийн үйл ажиллагаа”-ны хүрээнд Баянхангай, Баянцагаан, Лүн, Эрдэнэ сумдад мах бэлтгэл, түүхий эд бэлтгэлийн анхан шатны болон дундын хоршоо байгуулагдаж, ШИНЭ МАХ төслийг хэрэгжүүлж эхэллээ.

Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг санхүү, зээлийн бодлогоор дэмжиж тусгай сангуудаас болон эдийн засгийн сэргээх хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээлд оны эхний хагас жилийн байдлаар 178 иргэн, аж ахуйн нэгжид 9148.5 сая төгрөгийн зээл олголоо. Үүнд: Аймаг хөгжүүлэх сангаас 37 төсөлд 962.0 сая төгтөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 5 төсөлд 118.5 сая төгрөг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 21 төсөлд 637.0 сая төгрөг, “Хөдөө аж ахуйг дэмжих” 3 хувийн хөнгөлөлттэй зээлд 115 иргэн, аан 7431.0 сая төгрөг олгов.

Баялаг бүтээгчдийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих зорилгоор аймгийн төвд “Хөдөлмөрийн амт” 1 удаа, Алтанбулаг Баянчандмань, Баянхангай, Баянцогт, Баянчандмань Эрдэнэсант, Зуунмод суманд “Сумандаа үйлдвэрлэв” 7 удаа, нийт 8 удаагийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, давхардсан тоогоор 110 иргэн, аж ахуйн нэгж 200 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 114.0 сая төгрөгийн борлуулалтаар дэмжигдлээ.

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР:

Тохирлын үнэлгээнд хамрагдахаар хүсэлт ирүүлсэн 5 сумын 16 аж ахуйн нэгж, иргэний худалдаа, үйлчилгээний цэг, бүтээгдэхүүнд үнэлгээ хийж тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олгох, сунгах үйлчилгээ үзүүлсэн.

Баян, Баянчандмань, Борнуур, Лүн, Угтаалцайдам, Цээл, Сэргэлэн, Эрдэнэ Эрдэнэсант сумдын худалдаа, үйлчилгээний эрхлэгчдийн үйл ажиллагаанд ашиглаж буй хэмжлийн 2 төрлөөр нийт 88 ширхэг хэмжих хэрэгсэл шалгаж баталгаажуулсан.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Аймгийн Засаг даргын А/234 дугаар захирамжийн дагуу ой бүхий Эрдэнэ, Баяндэлгэр, Мөнгөнморьт сумдад Хуурайшилтын үед ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хууль бус мод бэлтгэлийг шалгах, мөн ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөлүүдэд менежментийн төлөвлөгөө бичих, тайлагнах ажилд зөвлөн тусалсан.

“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”, мод тарих өдрөөр 27 сумын 4268 иргэн, 1126 аж ахуйн нэгж байгууллага 27.5 га талбайд 54685 ширхэг мод тарьсан байна. Мөн “Оюу толгой” ХХК-аас нийгмийн хариуцлагын хүрээнд 30000 хайлаасыг өгснийг ой бүхий 14 суманд хувиарлан нийтийн эзэмшлийн талбайд тарилт хийлээ.

Ард иргэдийг эрүүл, аюулгүй, стандартад нийцсэн усаар хангах чиглэлээр сум, суурин газрын ундны усны эх үүсвэрийн худагт ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмжийг үе шаттайгаар суурилуулах ажлыг 2018 оноос хойш зохион байгуулж байгаа бөгөөд 2022 онд Алтанбулаг, Батсүмбэр, Жаргалант сумдын 3 худагт ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах ажлыг гүйцэтгэгч “Вотер фильтр” ХХК-тай гэрээ байгуулж, ажлыг эхлүүллээ.

Зуунмод сумын ОНХС-ийн 29.0 сая төгрөгийн хөрөнгөөр Зүүндэлгэр, Нацагдорж багт ус түгээх цахим худаг суурилуулахаар төлөвлөн, гүйцэтгэгчийг шалгаруулах шатандаа ажиллаж байна.

Барилга хот байгуулалтын дэд сайд, Байгаль орчин аялал жуулчлалын яамны Байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга, Төв аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Сэргэлэн сумын 1-р багийн нутагт Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих 20 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авхуулах ажлын бэлтгэл ажлыг хангуулах зорилгоор сумын ИТХ-ын төлөөлөгчид, сумын иргэдэд төслийн урьдчилсан төлөвлөлт, байгаль орчны суурь судалгааны танилцуулга мэдээлэл өгч, иргэдийн санал бодлыг сонсох ажлыг зохион байгуулав.

Ковид-19 халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 3-р сарын 22-ноос 4 хоногийн хугацаатай хяналт шалгалтыг Заамар суманд хийж гүйцэтгэв. Шалгалтаар 15 аж ахуйн нэгж хамрагдаж 5 аж ахуйн нэгжид тус бүр 1.0 сая төгрөгийн торгууль 3 аж ахуйн нэгжид хугацаатай албан шаардлага хүргүүлэв.

Аймгийн ИТХурлаар батлагдсан “Аялал жуулчлалын стратеги төлөвлөгөө”-нд тусгагдсан аялал жуулчлалын орон зайн төлөвлөлт, бүсчлэлийг аймгийн газарзүйн байршил, байгаль

цаг уурын онцлог, нийгэм эдийн засгийн нөхцөл нөөцийг харгалзан аялал жуулчлалын 5 бүс буюу 1. Зуунмод орчмын аялал жуулчлалын бүс, 2. Тал хээрийн аялал жуулчлалын өмнөд бүс, 3. Хөдөө аж ахуй, амралт чөлөөт цагийн Хойд бүс, 4. Хэнтийн нуруу, Хэрлэн голын байгаль түүхийн аялал жуулчлалын Зүүн бүс, 5. Бат хан уул, Туул голын байгаль нүүдэлчин ахуйн Баруун бүс гэсэн 5 бүсээр аялал жуулчлалын нөөц, даацын судалгаа хийгдэж, бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэхээр “Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэх боломж” сургалт зохион байгуулж, Баян, Баянжаргалан, Лүн, Мөнгөнморьт Эрдэнэ, Эрдэнэсант сумдын 120 гаруй малчин өрхийг хамрууллаа.

УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

Газар тариалангийн бүс нутгаар зонхилон, баруун өмнөдийн, баруун хойдын процесстой үед 4 удаа гарч байрлан 10 удаа үйл ажиллагаа явуулсан. Үйл ажиллагааны үр дүнд: 05 дугаар сард нийт нутгийн 9.5% нь /ОЖД/-аас ахиу, 38.1% нь /ОЖД/-ийн орчим, 52.4% нь /ОЖД/-аас бага хур тунадас орсон нь нийт нутгийн 47.6 орчим хувьд ЦАЗНА амжилттай болов. Газар тариалангийн бүс нутаг болох Борнуур 0.2 мм, Цээл 3.2 мм, Нөхөрлөл 4.1 мм, Батсүмбэрт 13.7 мм-ээр, бусад нутгаар Дэлгэрхаан 2.4 мм-ээр хур тунадас нэмэгдүүлсэн байна.

Нарийвчилсан мэдээ, 1 хоногийн мэдээ, 5 ба 7 хоногийн мэдээ, сарын болон улирлын мэдээ, өнгөрсөн 1 болон 7, 10 хоног тутмын цаг агаарын тойм, өдөр тутмын цаг агаарын мэдээ, цаг агаарын аюултай үзэгдлээс анхааруулах мэдээ 3 удаа, сэрэмжлүүлэх мэдээ 2 удаа гаргаж Зуунмод сумын ОНИМ-ийн ажилтанд и-мэйл ба “Дотоод удирдлагын систем”-ээр явуулах ажил тасралтгүй хийгдэж, байгууллагын урсдаг гэрлэн самбарт нарийвчилсан, хоногийн мэдээг өдөр бүр байршуулан ард иргэдэд үйлчилж байна. Цаг агаарын аюултай үзэгдлээс анхааруулах болон сэрэмжлүүлэх мэдээг “Багц мессеж”-ээр нийт давхардсан тоогоор 19947 иргэнд хүргэж үйлчиллээ.

Агаарын чанарын хүхэрлэг хий, азотын давхар ислийн сорьц авч, шинжилгээг хийн агаарын чанарыг тодорхойллоо. Агаарын чанарыг 06 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар нийт 30 удаа ажиглалт хийсэн ба хүхэрлэг хийн дундаж агууламж 0.004 мг/м^3 , азотын давхар ислийн дундаж агууламж 0.013 мг/м^3 үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүхэрлэг хийн дундаж агууламж өөрчлөлтгүй 0.001 мг/м^3 -ээр, азотын давхар ислийн дундаж агууламж 0.009 мг/м^3 -ээр нэмэгдсэн үзүүлэлттэй гарсан. Гадаргын усны чанар: Усны чанарын хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу 06 дугаар сард Туул-Лүн, Туул-Заамар голуудын хяналт шинжилгээг хийхэд цахилгаан дамжуулах чанар нь Туул-Лүн 282 uS/cm , Туул-Заамар 345 uS/cm гарлаа.

Хэрлэн голын дагуух ус судлалын харуулуудын усны түвшин үерийн түвшингээ даван үерлэсэн учир хур борооны сэрэмжлүүлэх мэдээг www.tuv.tsag-agaar.gov.mn болон Монгол орны гол мөрөн, нуурын усны түвшин цахим хуудасанд 8 удаа байршуулж, сум орон нутгийн удирдлагууд болон холбогдох мэргэжилтэнд тухай бүр хүргэж үйлчиллээ.

ДОЛОО. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн ЗДТГазар болон MERIT төслийн хамтын ажиллагааны хүрээнд 2022 оны 05 сарын 24-ний өдрөөс Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт цахим сургалтыг зохион байгуулж, хэлтэс агентлаг байгууллагын 200 албан хаагч хамрууллаа.

Зүүн бүсийн сумдын ахмадын уулзалт, тэмцээнийг Баян суманд 6 дугаар сарын 07,08 ны өдрүүдэд Архуст, Баяндэлгэр, Баянжаргалан, Баянцагаан, Зуунмод, Мөнгөнморьт, Сэргэлэн, Эрдэнэ сумын ахмадуудыг хамруулан зохион байгууллаа.

ГЭР БҮЛ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭ

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан 2021-2022 оны хичээлийн жилд аймаг, улс, бүс, тив, дэлхийн чанартай уралдаан тэмцээнд оролцож амжилт үзүүлсэн хүүхдүүдэд аймгийн Засаг дарга, Хүүхдийн төлөө зөвлөлийн нэрэмжит "Амжилтын од" медалиар 63 хүүхдийг шагнаж урамшууллаа.

Аймгийн Хүүхдийн Нэгдсэн зөвлөлөөс санаачлан **“Чөлөөт индэр”** ярилцлагын нэвтрүүлэг, **“Хүүхдийн дуу хоолой”** подкаст чөлөөт ярилцлагын нэвтрүүлэг, **“Хүүхдийн нэг өдөр”** өдөрлөг, **“Сониуч дуран”** хүүхдийн сурвалжлага нэвтрүүлгүүдийг бэлтгэн хүргэсэн.

Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг “Нэгдүгээрт хүүхэд” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж, “Яргуй-2022” наадамд шалгарсан 81 хүүхдийн урлагийн тоглолтыг Монгол туургатан театрт хамтран найруулан тавьсан. Мөн урлаг, спорт, сурлагын амжилт гаргасан “Шилдэг 9” сурагчийг алдаршуулж, шагнал гардууллаа.

Хүүхдийн баярын арга хэмжээний хүрээнд “3 эсрэг 3” сагсан бөмбөгийн тэмцээн, “Гоолын баяр” хөл бөмбөгийн нээлттэй тэмцээн, ширээний шагайн наадгай, гийр өргөлт, хөл бөмбөгийн жонглёр, дугуйтай туг сүлжих, хууринан шуугигч, чанга шивнээ, ролики, скутер зэрэг тэмцээн, уралдаан зохион байгуулж, 784 хүүхдийн хөгжил, оролцоог хангаж ажиллалаа.

Хүүхдэд зориулсан үзвэр үйлчилгээний хүрээнд “Сарьсан багваахайн домог” хүүхдийн жүжиг, “Сахиусан тэнгэрүүд” кино контент, Ойн түүх, Музейн үнэ төлбөргүй үзвэр үйлчилгээ, шинэ номын худалдаа, “Дурсамжаа бүтээе” зураг авалт, “Томчуудаас хүсэх хүсэлт” бичих нээлттэй самбар, Хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ТББ-уудын үйлчилгээ, ахлах ангийн сурагчдын “Open voice” чөлөөт арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 3700 гаруй хүүхдэд хүрч үйлчилсэн.

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх “Сайн дурын гишүүн” хүүхдүүд Мөнх-Алдарын талбайд хоггүй цэвэр цэмцгэр баярлах хүрээнд “Нэг хог-Нэг чихэр” арга хэмжээг зохион байгуулсан.

Сурагчдын зуны амралт эхэлсэнтэй холбоотой хүүхдийн амралт чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх зорилгоор “Зуны зугаатай өдрүүд” бидэнтэй хамт бүжиглээрэй арга хэмжээг Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх бүжгийн дугуйлангийн хүүхдүүдийн хамт 2022.06.20-24-ний өдрүүдэд Мөнх-Алдарын талбайд зохион байгууллаа.

Хүүхдийн тусламжийн утас 108-д 06 дугаар сарын байдлаар 16 мэдээлэл ирснээс:

- Бие махбодийн хүчирхийлэл-4
- Үл хайхрах -4
- Бэлгийн хүчирхийлэл-2
- Сэтгэл санааны хүчирхийлэл-2
- Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр /хурдан морь/-3
- Хууль зүйн зөвлөгөө хүссэн-1 дуудлага ирсэн. Үүнээс 2 дуудлага хаасан, бусад дуудлагад хариу үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Эрдэнэ суманд хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээгээр ажиллаж, ЕБС-ийн 50 сурагчид “Үе тэнгийн дээрэлхэлт” сэдвээр сургалт зохион байгуулсан. Мөн 2022.06.20-24 өдрүүдэд Зуунмод сумын төв талбай дээр зохион байгуулагдсан “Зуны зугаатай өдрүүд” арга хэмжээний хүрээнд Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгийн Төв аймаг дахь салбарын “Өсвөрийн эмч” клубын гишүүдтэй хамтран хүүхэд багачуудад мини театраар:

- “Миний биеийн аюулгүйн дүрэм”
- “Гар утас бол чиний найз биш”

- “Үе тэнгийн дээрэлхэлт” сэдвүүдээр жүжигчилсэн тоглолт үзүүлж, танин мэдэхүйн мэдээлэл хүргэн давхардсан тоогоор 100 хүүхдэд үйлчилсэн.

“Хүүхдийн мөнгө” зогсоох тухай 2 хүсэлт хүлээн авч шийдвэрлэж 1 хүүхдийн мөнгөний хүсэлт сэргээсэн.

Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага MNS 5633:2019 стандартын хэрэгжилтийг хангуулах, тохиролын гэрчилгээ олгох зорилгоор аймгийн Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Цагдаагийн газартай хамтран Төв аймгийн Батсүмбэр, Жаргалант, Эрдэнэ сумдын нутаг дэвсгэрт байрлах “Мөрөөдөл”, “Цоглог”, “Цагаан нуга”, “Скаут”, “Хайрын билэг-1”, “Од” зуслангуудад хяналт шалгалт хийж тохиролын гэрчилгээ авахад бүрдүүлэх материалын талаар зөвлөн тусаллаа.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулиудын хэрэгжилтийг хангах, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эцэг эх, хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө мэдээллийг анхан шатанд, газар дээр нь хүрч үйлчлэх, хүүхдийн өмнө үүрэг хүлээгчид, хамтарсан багийн гишүүдийг ажлын байранд нь чадавхжуулах, мэргэжил арга зүйгээр хангах зорилгоор “Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ”-г Эрдэнэ суманд зохион байгууллаа. Явуулын үйлчилгээний хүрээнд “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”, “Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал” сургалтыг 13 багш, эцэг эхэд, “Үе тэнгийн дээрэлхэлт”, “Өсвөр насны хүүхдийн сэтгэл зүйн онцлог” сэдэвт сургалтыг 60 гаруй хүүхдэд тус тус зохион байгууллаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 5 өрхөөр орж, нөхцөл байдлын үнэлгээ хийн, хэрэгцээг тодорхойлсон. Сэтгэл зүйн зөвлөгөөг 2 хүүхдэд, “Шууданч тагтаа” явуулын саналын хайрцагаар 3 саналыг хүүхдээс авч ажилласан. Нийт 5 өрх, 13 багш, эцэг эх, 70 хүүхдэд явууллын үйлчилгээгээр хүрч үйлчилсэн байна.

Аймгийн Цагдаагийн газар, Залуучууд хөгжлийн төвтэй хамтран Цагдаагийн газрын түр саатуулах байранд гэр бүлийн хүчирхийлэл, замын хөдөлгөөний зөрчлөөр 7-30 хоногоор баривчлагдсан нийт 37 хүмүүжигчид зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтыг “Хувь хүний хөгжил”, “Харилцаа” сэдвээр 2 удаа зохион байгуулсан.

Долоо хоног бүрийн Баасан гарагийн 17:00 цагт “ГЭР БҮЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ЦАГ” нэртэй мэдээллийг “Аз жаргалтай гэр бүлийн 8 нууц”, “Хүүхэд насны хөгжил ба сэтгэл зүй”, “Хүүхэддээ мөнгөний талаар хэдэн наснаас нь зааж эхэлвэл зүгээр вэ?”, “Өрхийн эрүүл мэнд” зэрэг 4 сэдвээр постер бэлтгэн байгууллагын цахим хаягт байршуулж, иргэдэд мэдээлэл хүргэлээ.

Аймгийн ГБХЗХГазар Залуучуудын хөгжлийн төв нь Сайн дурын үйл ажиллагаа, хүмүүнлэгийн ажилд оролцдог залуучуудыг дэмжих, тэдний хийсэн сайн дурын үйлс нийгэмд болон өөрийн амьдралд хэрхэн нөлөөлж буйг олон нийтэд таниулах, сурталчлах зорилгоор “Сайн дурын ажил миний амьдралд” сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг Төв аймгийн хэмжээнд зохион байгууллаа. Уралдаанд Зуунмод, Сэргэлэн, Мөнгөнморьт, Баян сумдууд оролцлоо.

“Сумын хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо-2022” арга хэмжээг Баяндэлгэр сумтай хамтран зохион байгуулсан. Үйл ажиллагаанд Mind сэтгэл судлалын төвийн үүсгэн байгуулагч А.Батбаяр оролцож нийт 220 эмэгтэйчүүд хамрагдсан. “Малчдын зөвлөгөөн”-ийг Эрдэнэсант суманд хамтран зохион байгуулж, аймгийн Залуучуудын хөгжлийн төв, Аймгийн залуучуудын холбоо, Баялаг бүтээгчдийн холбоо, Mint сэтгэл судлалын төвийн үүсгэн байгуулагч, Сэтгэл судлаач, Доктор Ө.Батбаяр нар хамтран 280 иргэнд сургалт “Жирэмсэн

эмэгтэйн сэтгэл зүй-Халамжтай аав” сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан.

"Эх оронч-Залуу" цуврал подкастын хоёр дугаарыг Төв телевизтэй хамтран бэлтгэж олон нийтэд хүргэсэн. Нэвтрүүлэгт аймгийн ОБГ-ын Ахлах мэргэжилтэн, Ахмад Г.Отгонбаатар, аймгийн Цагдаагийн газрын мөрдөн байцаах тасгийн мөрдөгч, Цагдаагийн ахмад Н.Бадамжунай нар оролцсон бөгөөд хандалтын тоо 1540 байна.

Залуучуудын хөгжлийн төвийн фэйж хуудсыг сургалчлах, гишүүдийг нэмэгдүүлэх, нэвтрэлтийг хялбаршуулах зорилгоор QR кодтой болж, цахимд байршуулж 1216 иргэний хандалт авч ажиллалаа. Тайлант хугацаанд Залуучуудын хөгжлийн төвийн фэйж хуудсанд 32 постер, мэдээлэл байршуулж 7045 хандалт, 1475 удаа хуваалцсан байна

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн 5 өргөдөл, гомдол, 12 албан бичгийг хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариу өгч ажилласан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналт шалгалтын газраас хэлтсийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэж “Нийгмийн даатгалын тухай хууль”-д заасан болзлоор малчин, хэвийн бус нөхцлөөр тэтгэвэр тогтоолгохдоо хуурамч материал бүрдүүлсэн байж болзошгүй 14 тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэргийг шалгуулахаар Цагдаагийн газрын мөрдөн байцаах тасагт шилжүүлсэн.

2021 онд шинээр тогтоогдсон болон шилжиж ирсэн 1310 тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэргээс 912 хувийн хэргийг шалгаж 251 хувийн хэрэгт баримт бичгийн зөрчил илрүүлэн нөхөн бүрдүүлэлт хийж, баримтын зөрчлийг арилгуулж ажилласан. 2021 онд малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох сум дахь орон тооны бус байнгын зөвлөлийн тогтоолын үндэслэлд шалгалт хийж 173 тогтоолыг хамруулан шалгасан.

Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх ЭХМК-ын хурлыг 5 удаа хуралдаж, нийт 229 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 29 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, 192 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 18 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын актыг цуцалсан байна.

Жирэмсэн амаржсаны тэтгэмж 559 даатгуулагчид 944,5 сая, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 932 даатгуулагчид 123,2 сая, ажилгүйдлийн тэтгэмж 251 даатгуулагчид 575,5 сая төгрөг тус тус олгосон байна. Хаан банк болон Төрийн банкаар дамжуулан аймгийн хэмжээнд 17347 тэтгэвэр авагчдад 8,3 тэрбум төгрөгийн тэтгэврийг олгон ажилласан.

ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

2022 оны 6-р сарын байдлаар 1896 иргэнд 3046.5 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1216 иргэнд 605,1 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 1045 иргэнд 474.4 сая төгрөгийн амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж, 18 иргэнд 21,6 сая төгрөгийн онцгой тохиолдолын мөнгөн тэтгэмж, 9361 эхэд 1215,1 сая төгрөгийн “Алдарт эх” 1, 2-р зэргийн одонтой эхийн мөнгөн тэтгэмж, 5630 ахмад настанд 454,6 сая төгрөгийн насны хишиг, 956 ахмад настанд 180,6 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, 162 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 43,6 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, хүнс тэжээлийн тусламж шаардлагатай 4082 иргэнд 317,1 сая төгрөг, жирэмсэн 680 эхэд 137.5 сая төгрөгийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 4289 эхэд 1194.5 сая төгрөгийн тэтгэмж, Өрх толгойлсон 315 эх /эцэг/-т 128,4 сая төгрөг, ихэр хүүхэд төрүүлсэн 16 ихэр хүүхдэд 32,0 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд 4 иргэнд 6,9 сая

төгрөг, 33850 хүүхдэд 20257,8 сая төгрөг, амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулалд 125 иргэнд 5,1 сая төгрөгийг тус тус олгосон.

Шинээр “Алдарт эх”-ийн 1,2 дугаар одон авах 369 эхэд одон гардуулах ёслолын арга хэмжээг АЗДТГ-ын НБХ, ИТХурлын ажлын албатай хамтран зохион байгуулсан. Холт ОУХүүхдийн байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг “Хүүхдийн амьжиргааг дэмжих төсөл”-д хамрагддаг байнгын асаргаатай болон зорилтот өрхийн 50 хүүхдэд 1,5 сая төгрөгийн хүүхдийн баярын бэлэг гардуулж өгсөн.

Жаргалант сумын мал маллах хүсэл сонирхолтой 4 өрхийг МХЭДХөтөлбөрт хамруулж 5,0 сая төгрөгийн мал хүлээлгэн өгсөн. Мөн “Гэр бүлийн баяр хөөр” сургалтыг зохион байгуулж, зорилтот бүлгийн “Гэрээр айлчилъя” хөтөлбөрт хамрагддаг 100 өрхийн 38 иргэнийг хамруулсан.

Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх Оролцоо төсөлд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 4 иргэнийг хамруулсан. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг хөдөлмөрийн насны 19 иргэнд хөдөлмөрт бэлтгэх сургалтын мэдээлэл өгч 6 иргэнийг танхим, 1 иргэнийг цахимаар, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөөнд Зуунмод сумын 25 иргэнийг хамруулсан. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг 757 өрхийн 4082 иргэнд олгож хүнс тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийлж ажилласан. Хүүхдийн мөнгө ороогүй банкны КАМ шалгуур хангаагүй 279 хүүхдийн мэдээллийг эцэг эх асран хамгаалагчид мэдээлж мэдээллийг засч ихаламж программд бүртгэсэн.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 6-р сарын байдлаар 72 ажил олгогч, 106 иргэнийг ажил хайгчаар бүртгэсэн. Шинээр бий болсон 245 /нийт 512/-н шинэ ажлын байрыг бүртгэн мэдээллийн санд оруулсан. Нийт 68 ажил олгогчийн 155 сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг хүлээн авч 94 /нийт 362/ иргэнийг ажилд зуучилсан. Ажилгүйдлийн тэтгэмжинд хамрагдах 65 иргэний бүртгэлд хамрагдсан тодорхойлолтыг Нийгмийн Даатгалын Хэлтэст хүргүүлсэн. Түр ажлын байранд ажилласан нийт 1753 /нийт 4686/ иргэнийг бүртгэж мэдээллийн санг үүсгэн ажиллалаа

Аймгийн хэмжээнд Оролцоо төслийн бүртгэлд 47 иргэн бүртгүүлж ярилцлагад хамрагдсанаас 34 иргэн тэнцсэн. Үүнээс 1-р ээлжийн сургалтад 18 оролцогч хамрагдан 14 хоногийн вакумжуулсан сургалтад хамрагдаад байна.

Тайлант хугацаанд 14 иргэний 35885,7 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт ХЭДСанд төвлөрч, өссөн дүнгээр 333 иргэний 257621,1 мянган төгрөг төвлөрсөн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн ажлын байрны төлбөрт тухайн сард НУБИЭ ХХК 21000,0 мянган төгрөг төлөгдсөн бөгөөд өссөн дүнгээр 68164,1 мянган төгрөг ХЭДСанд төвлөрсөн байна. ХЭДСанд 1051400,0 мянган төгрөгийн санхүүжилт ирж тайлант сард 175828,1 мянган төгрөгийг зарцуулсан.

ХХҮГазрын даргын 2022 оны А/24 тушаалаар байгуулагдсан Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн хуралдаанаас АМЧБОЗӨЙлчилгээ болон Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээг “Соноор эдүкэшин” сургалтын төвөөр зохион байгуулж, хамтран ажиллахаар шийдвэрлэсэн.

Бүлгийн сургалтыг Эрдэнэ, Жаргалант, Борнуур, Батсүмбэр, Мөнгөнморьт, Архуст, Баянжаргалан сумын ажил хайгч, ажилгүй нийт 70 иргэнд, ганцаарчилсан зөвлөгөө мэдээллийг Борнуур, Жаргалант, Эрдэнэ, Мөнгөнморьт, Баянжаргалан сумын ХЭБ-н үйлчилгээнд хамрагддаг өрхийн болон ажил хайгч, ажилгүй хөдөлмөрийн насны 156 иргэнд үзүүлж, хөдөлмөр эрхлэлтийн ур чадварт үнэлгээ хийн, хувийн төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хурлыг Баянжаргалан, Баянчандмань, Жаргалант сумдад цахимаар Борнуур, Батсүмбэр суманд зохион байгуулж ААЭДХөтөлбөрт

14 иргэний 96,0 сая ₮-н, ХБИХЭДХөтөлбөрт 1 иргэний 5,0 сая ₮-н, АХЭДХөтөлбөрт 15 иргэний 70,0 сая ₮-н санхүүжилтийг иргэдэд олголоо. Жаргалант, Борнуур, Батсүмбэр сумын 16 малчинд сүүний чиглэлийн 67 толгой үхрийг хүлээлгэн өгч иргэдийн өрхийн амьжиргаанд 80,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг ХЭДСангаас зарцууллаа.

ХЭДСангийн санхүүжилтээр бизнесийн үйл ажиллагаа явуулж буй иргэдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулах Зуунмод сумын “Төв Керамик” компанийн борлуулалтын цэгт 600,0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон. Хөдөлмөрийн амт үзэсгэлэн худалдаанд борлуулагдаагүй 7 сумын 10 бизнес эрхлэгчийн 23,4 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг борлуулж, иргэдэд дэмжлэг үзүүллээ.

Ахмадын ХЭДХөтөлбөрийн хүүхэд хамгаалагч арга хэмжээнд хамтран ажиллаж буй 2 иргэний сарын ажлын тайланг хүлээн авч, 560,0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон. Шинэ нисэх онгоцны буудлын гадна хамгаалалтын ажилд шалгарсан Бамбай секюreti хамгаалалтын албантай хамтран ажиллаж сул ажлын байрны зарыг иргэдэд хүргэн ажилд орохоор нийт 15 ажил хайгч бүртүүлснээс 6 иргэнийг ажилд авахаар тохирч, сургалтыг 2022.06.29-нд эхлүүлэхээр болсон.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР

Аймгийн хэмжээнд 2022 оны 6 дугаар сарын байдлаар 318 эх амаржиж 322 нярай мэндэлсэн байна. Жирэмсний хяналтад нийт 718 эх байгаагын 571 эхийг шинээр хяналтад авсан бөгөөд эхний 3 сартай хяналтад 91.07% нь хамрагдсан. Нийт 130346 хүнд үзлэг хийсэн, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 40662, амбулаторийн үзлэг 72930, идэвхитэй хяналтын 11416 үзлэг хийсэн байна. Түргэн тусламжийн дуудлагаар 7271 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн ба үүнээс алсын дуудлага 24.73%, осол гэмтлийн дуудлага 2.49%-ийг эзэлж байна. Стационарт 8342 хүн эмчлэгдэн нийт 62965 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7,5 байна.

2022 оны 06 дугаар сард Коронавируст халдвар /Ковид-19/-тай 62 иргэнийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамруулснаас, 49 иргэнийг эмчилж, нас баралт-1, одоогоор 12 иргэн эмчилгээнд хамрагдаж байна.

ЭМГ-аас 27 сумын ЭМТ-д ажиллаж урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэгийн зохион байгуулалт, хамрагдалтын явцад хяналт хийж, удаашралтай байгаа ажлыг эрчимжүүлэх чиглэл, албан даалгавар өгч ажиллав. 27 сумын онцгой комисс сумын эрүүл мэндийн төвүүдэд Коронавируст халдварын нэмэлт тунгийн дархлаажуулалтыг эрчимжүүлэх, хавьтал тандалт хийх арга зүйн чиглэлээр чадавхжуулах сургалт зохион байгуулсан.

Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд нийт 11920 иргэн хамрагдаж ehospital програмд баталгаажсан байна. Үүнд: эрэгтэй 5960, эмэгтэй 5960 байна. 0-5 насны хүүхэд 1015, 6-17 насны хүүхэд 9925, 18-30 насны иргэн 592, 30-аас дээш насны иргэн 388 хамрагдсан.

Цусны донорын–дэлхийн өдөр”-ийг аймгийн хэмжээнд зохион байгуулж, нийт 838 донорыг алдаршуулан, Аймгийн TBS телевизтэй хамтран “Гэр бүлийн хүнэдт донор” 3 гэр бүл, Залуу донор гэр бүлийг хамруулсан телевизийн нэвтрүүлэг зохион байгуулж, ард иргэдэд сурталчлан алдаршуулах арга хэмжээ зохион байгуулж нийт хандалт-16000 байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан “Аз жаргалтай төв” төслийн үйл ажиллагааг эхлүүлж Зуунмод сумын 3-16 насны 8 хүүхдийг хамруулаад байна. Хүүхдүүдэд эрүүл мэнд, боловсрол, нөхөн сэргээх тусламж үйлчилгээг 7 хоногт 2 удаа, өдөрт 3 цагаар хүргэж байна.

“Дэлхийн тамхигүй өдөр”-ийг Эрүүл мэндийн газар, Зуунмод сумын хүүхдийн зөвлөлийн сурагчидтай хамтран “Тамхинд биш Тархиндаа хөрөнгө оруулцгаая” уриан дор зохион байгуулж, 6 төрлийн мэдээлэл бэлтгэн Зуунмод сумын иргэдэд сурталчиллаа. Аймгийн ЗДТГ, ЭМГ, БТСГ, Нэпко компани хамтран “Алхалт” номын нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, өглөөний алхалт хийж нийт 126 хүн хамрагдсан.

Улсын тэргүүний Алтанбулаг сумын малчдын нэгдсэн зөвлөгөөнд оролцож урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн зохион байгуулалтын талаар мэдээлэл сурталчилгааг 100 гаруй иргэдэд өгсөн.

Батсүмбэр сумын Ахмад настны үндэсний төвийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, Хөдөлмөр нийгэм хамгааллын яамнаас томилогдсон ажлын хэсэгт ажиллаж, тус төвийн бүтцийг хэлэлцэн шийдвэрлэсэн. Эрдэнэ суманд байрладаг Өрмөн-уул группын харьяа Хайрын билэг-2 сувиллыг магадлан итгэмжлэлд хамруулсан.

Халдварт өвчний 7 голомтод ажиллаж, 456 мкв талбайд халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэсэн. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд ажлын байрны дадлагажуулах сургалт 1 удаа, танхимын сургалт 3 удаа, цахим сургалт 2 удаа, бүсчилсэн сургалтыг 2 удаа зохион байгуулж 349 иргэн хамрагдлаа.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

ЭМДЕГ-тай гэрээтэй Төв аймгийн 77 байгууллагаас 73 нэхэмжлэхээр 5914 иргэнд 484821969 төгрөгийн гүйцэтгэлийн нэхэмжлэх ирүүлснээс нэхэмжлэлийн хяналт хийж, 500 иргэний 12,6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 22180 иргэний 2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг ЭМБ-уудад олгох зөвшөөрлийг ЭМДЕГ-т хүргүүлсэн.


ЭМД-н тухай хуулийн өөрчлөлт шинэчлэлт, ЭМД-ын шимтгэл төлөлт, өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ, эрт илрүүлэг, гэрээтэй эрүүл мэндийн байгууллагуудын талаарх мэдээллийг 87 иргэнд хүргэсэн.

Төр хариуцах иргэний ногдуулалтыг цахимаар 34 /Төрсөн эх-30, ХБИ-4/, Ажлын байран дээр 21 /Төрсөн эх-16, ХБИ-5/ нийт 55 иргэнд хийв.

УБ Төмөр замын харьяа Булагтай ахмадын сувилалд 3 хүний бүрэлдэхүүнтэй хяналтыг хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ЭМДЕГ-т тайланг хүргүүлсэн.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Төсвийн шинэчлэл сургалтыг 2022 оны 06 сарын 02-ны өдөр зохион байгуулж Төв аймгийн 27 сумын сургуулийн захирал, сургалтын менежер, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, нягтлан бодогч, үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл болсон нийт 353 хүн хамрагдлаа



Элсэлтийн ерөнхий шалгалтыг Хүмүүн цогцолбор ахлах сургуулийн 20 танхимд Аймгийн Засаг даргын 2022 оны 6-р сарын 22-ны өдрийн А/470 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн, 38 хянагч, 8 зохион байгуулагч багшийн дэмжлэгтэйгээр 6 сарын 23-наас 26-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд 2398

шалгуулагч шалгуулахаас 2140 шалгуулж нийт шалгуулагчийн ирц 89%-тай байна. Хамгийн олон хүүхэд шалгалт өгсөн хичээл Математик -516, нийгэм-450, англи хэл-366, монгол хэл-280, хамгийн цөөн нь Орос хэл -7 хүүхэд шалгалт өгсөн байна.

Цагдаагийн газрын ажилтан болон Мэргэжлийн хяналтын байцаагч нар ЭЕШ-ын үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах, сэдэв, материалыг хүлээж авах, өгөх, шалуулагчдыг тусгай төхөөрөмжөөр шалгах, чиглүүлэх, засалтын үйл ажиллагаанд сэдэв хүргэх, шалгуулагчдыг гаргах үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд шалгалтын явцад зөрчил гараагүй.



Нэгдсэн мэдээг хүснэгтээр үзүүлбэл

№	Хичээл	Шалгуулагчийн тоо	Энэ оны төгсөгч	Анхны оноо	Хэмжээст оноо
1	Монгол улсын түүх	18	8	63.1	608.6
2	Англи хэл	366	321	29.8	484
3	Хими	137	113	24.8	502
4	Газар зүй	10	7	63.5	573.2
5	Нийгмийн тухай мэдлэг	450	395	51	504.02
6	Биологи	149	125	45.7	521.7
7	Математик	516	461	26.9	508.1
8	Физик	206	185	30.3	505.5
9	Орос хэл	8	7	71.5	599
10	Монгол хэл	280	241	55.3	526.1
	Нийт	2140	1863		

ЭЕШ-д бэлтгэх нэгдсэн сорилыг 2 удаа зохион байгуулж УИХ-ын гишүүн Ж.Батжаргалын нэрэмжит “Амжилтын хөтөч” Сорил-2-ыг БҮТ-тэй хамтран зохион байгуулж тус сорилд ЭЕШ-ын 10 судлагдахуунаар 20 сургуулийн давхардсан тоогоор 1805 суралцагч хамрагдаж, 180500 оноо авахаас 77596 оноо авч 43%-ийн гүйцэтгэлтэй шалгагдсан байна. Тэргүүлсэн 10 сурагч, масс сурагчдаа амжилттай бэлтгэсэн 10 багшийг шагнаж, “Амжилтын хөтөч” сорил зохион байгуулахад 4.8 сая төгрөг зарцууллаа.

Анги дэвших болон улсын шалгалтыг зохион байгуулж 5,9,12-р ангийн улсын шалгалтад 1158 бүлгийн давхардсан тоогоор 27157 суралцагч хамрагдаж, VII, VIII түвшинд үнэлэгдсэн сурагчдын эзлэх хувь 47.13, V, VI түвшинд үнэлэгдсэн сурагчдын эзлэх хувь 41.33, III, IV түвшинд үнэлэгдсэн сурагчдын эзлэх хувь 8.90, I, II түвшинд үнэлэгдсэн сурагчдын эзлэх хувь 2.64-тай дүгнэгдлээ.

БШУЯ, БЕГ, АХБ-тай хамтран зохион байгуулсан “Цэцэрлэгийн менежмент, манлайлал” и-сургалтад төрийн өмчийн цэцэрлэгийн 37 эрхлэгч хамрагдаж, 35 эрхлэгч амжилттай суралцаж Батламж гардан авлаа.

СОЁЛ, УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР

Соёлын яамнаас “Соёлын салбарын шинэтгэлийн бодлого” сэдэвт нэгдсэн сургалт, уулзалт, хэлэлцүүлгийг 06 дугаар сарын 07-09-нд танхимаар зохион байгуулж СУГ, ННС, МТТ, Музей болон 27 сумын соёлын төвийн дарга нар хамрагдлаа.

Монголын урлагийн ажилтны холбоотой хамтран Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин, Төрийн шагналт Л.Цогзолмаагийн нэрэмжит “Монгол ардын богино дуу дуулаач мэргэжлийн дуучдын улсын VII уралдаан”-ыг аймгийн Монгол туургатан театрт 06 дугаар сарын 14-18-нд амжилттай зохион байгууллаа.

Зуунмод сумын ЕБС-ийн сурагчдын дунд сонгодог урлагийг хөгжүүлэх зорилгоор “Хийлийн дугуйлан”-г хичээллүүлж, дугуйлангийн сурагчдаас олон улсын уралдаанд “ГУТГААР” байр эзэлсэн 3 сурагчид хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг гардууллаа.

НИЙТИЙН НОМЫН САН

Нийтийн номын сан нь 06 дугаар сард танхимаар 129 байнгын уншигч, 1954 иргэнд 1649 ном олгож үйлчилсэн байна. Нийт 129 уншигч шинээр карт нээлгэснээс 44 эрэгтэй, 85 эмэгтэй уншигч байна. 27 сумын номын санд 1035 байнгын уншигч, 2500 иргэн үйлчлүүлсэнээс 230 иргэнд шинээр карт нээж, 5868 номоор үйлчилгээ үзүүллээ.

Зөөврийн номын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хөдөө орон нутгийн алслагдсан багийн иргэдэд үйлчлэх тоо, чанарыг ахиулах ажлын хүрээнд Бүрэн, Дэлгэрхаан, Өндөрширээт сумдын Соёлын төвийн номын санчтай хамтран нийт 75 номыг 2 сарын хугацаатайгаар “Зөөврийн номын сан”-ийн үйлчилгээ хүргэсэн. 06 дугаар сард **76** иргэнд **109** номоор үйлчиллээ.

Нийтийн номын сан нь Ланс 2-р баг, Номт 1-р баг, Баруун-Зуунмод 6-р багтай хамтран “ЗУГААТАЙ ЗУНЫ ХӨГЖИЛТЭЙ УНШЛАГА” арга хэмжээг хүүхэд багачуудын дунд зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд “Номын уншлага” хийж Үлгэрийн ном, Оюун ухаан, Танин мэдэхүй, Адал явдалт номнуудыг уншиж, дүгнэлт хийн утга санааг хамтран ярилцлаа. Уншигч хүүхдүүддээ зориулан Нэг төө өвгөн, Нугасны муухай дэгдээхэй, Ухаантай хүү, Худалч гүнж зэрэг үлгэрүүдийг дэлгэцээр үзүүлж, үлгэрээс авах сургамж, эерэг ба эсрэг дүрүүдийн тухай үеийн найзтайгаа хамтран ярилцсан. “АХА” тэмцээн, эвлүүлдэг “PUZZLE” зэрэг тоглоомуудыг хүүхдүүдийн дунд зохион байгуулж 102 уншигч хүүхэд багачууд хамрагдлаа.

Аймгийн Нийтийн номын сан нь ADRF Mongolia Төв аймаг дахь салбартай хамтран Шуурайн Солонгын “УЛААН СУДАР” номоор 8-12 дугаар ангийн 12 сурагчийн дунд номын хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Ном унших соёлд гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэн, айл өрх бүрийг “Өрхийн номын сан”-тай болгох зорилгоор шинэ номын худалдаа, номын хандивын аян зохион байгуулж хандиваар цугларсан номыг 6 багийн 12 өрхөд 75 номоор, алслагдсан Ланс 2-р баг, Баянхошуу 3-р багт номын буланг байгуулж өглөө. Нийт 27 сумын 28574 өрхийн 6304 өрх номын сантай болсон нь 22%-тай байна.

МОНГОЛ ТУУРГАТАН ТЕАТР

Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт Панфилова Рыжковагийн зохиол “**ШИВШЛЭГТЭЙ ЗУРГИЙН НУУЦ**” хүүхдийн жүжгийг шинээр найруулан тоглов.

Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын уран зохиолч Б.Лхагвасүрэнгийн цомнол, Төрийн шагналт Х.Билэгжаргалын хөгжим “**ЛАМБУГАЙН НУЛИМС**” дуурийг шинээр найруулж үзэгчдэд толилууллаа.

“ГЭГЭЭН МУЗА-16” олон улсын урлагийн наадамд УГЗ Ш.Гүрбазарын зохиол “**ШАР ГЭГЭЭ**” драмын жүжиг шалгарч 6 номинацид нэр дэвшснээс “**ШИЛДЭГ ТАЙЗНЫ ЗУРААЧ**”-аар МТТ-ын зураач С.Бат-Эрдэнэ шалгарлаа.

АЙМГИЙН МУЗЕЙ

Музейгээс өссөн дүнгээр 18578 иргэн үйлчлүүлсэн бөгөөд эрэгтэй-8789, эмэгтэй -8789 иргэн байна. Үүнээс насанд хүрэгч 3211, хүүхэд 15272, гадаад үзэгч 95 байна. Музейн үзэл баримтлал, үзүүлэлэг дэглэлтийн талаар Японы соёлын өвийн Гадаад хамтын ажиллагааны консерваторын гишүүн сэргээн засварлагч, консерватор, доктор О.Ангарагсүрэнтэй зөвлөлдөх уулзалтыг цахимаар зохион байгууллаа.

Польш улсын Гадаад харилцааны сайдын албан айлчлалын хүрээнд Төв аймагт ажилласан өдөр Музейн үзүүлэгийг үзүүллээ. Зуунмод сумын 3-р багийн өндөр настан Ц.Цэрэннадмидаас “Тэмээн жинг”-ийн хэрэглэгдэхүүн хөллөгөө, хом ширдэг, шатыг өөрөө хийж Музейд хандивласныг хүлээн авч үзүүлэгт баяжилт хийлээ.

БИЕЙН ТАМИР СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР

“Монгол Улсын Засгийн газрын “Олимпизмыг дэлгэрүүлэх, хүний хөгжлийн шалгуур үзүүлэлтийг хангах, амьдралын чанарыг дээшлүүлэх үндэсний хороо”-ны үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулсан “Олимпын боловсрол ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт хоёр дахь удаагийн болзолт уралдаанд Төв аймаг амжилттай оролцон Хүмүүн цогцолбор сургууль ШИЛДЭГ СУРГУУЛЬ, БТС-ын Газар шилдэг БТС-ын байгууллагаар тус тус шалгарлаа.



Зуунмод сумын 80-н жилийн ойг угтаж байгууллага орчноо тохижуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын гадна талыг будаж өнгө үзэмжийг нь сэргээн, 412 ширхэг навчит шар хуайсыг шинээр суулгав.

Аймгийн ЗДТГ-ын нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, спортын төрлийн секц дугуйлангуудын сургалт дасгалжуулаглт, амжилтыг иргэдэд сурталчилах нээлттэй хаалганы өдөрлөгийг Монголын тамирчдын баярын өдөр 2022.06.26-нд хамтатган зохион явуулж 150 гаруй тамирчид, дасгалжуулагчид, иргэдийг хамруулсан.



Эх үрсийн баярын өдрийг “НЭГДҮГЭЭРТ ХҮҮХЭД” уриан дор зохион байгуулж хүүхдүүдийн



дунд спортын 5 төрөлт тэмцээнийг зохиож 432 хүүхдийг хамруулсан .

Заамар сумын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах “Граунд гольф”-ын тэмцээнийг 2022.06.04-ний өдөр Заамар сумын ЗДТГ, Төв аймгийн БТСГазар хамтран зохион байгууллаа. Уг тэмцээнд 5 багийн 34 тамирчин оролцлоо.



Ахмадын хөдөлгөөн-Эрүүл мэнд Зүүн бүсийн өдөрлөгийг 2022.06.07-нд Баян суманд зохион байгуулж 9 сумын 215 ахмад хамрагдаж спортын 3 төрлөөр өрсөлдлөө.



Аймгийн аварга шалгаруулах МИНИ волейболын тэмцээнийг 2022 оны 06-р сарын 11-12 ны өдрүүдэд Заамар суманд зохион байгуулж 10 сумын 85 багийн 370 тамирчин 8-12 нас, 13-14 насны ангилалаар өрсөлдлөө.



Нутгийн өөрөө удирдах байгууллага үүсч хөгжсөний 30-н жилийн ойн нэрэмжит үндэсний бөхийн барилдааныг 2022.06.11-нд зохион байгуулж 32 бөх барилдсан.



“ДУГУЙТАЙ ТӨВ АЙМАГЧУУД” аяныг 2022.06.15-нд зохион байгуулж Алтанбулаг, Батсүбмэр, Зуунмод сумын 70 гаруй дугуй сонирхогчид, өсвөрийн шигшээ багийн тамирчид оролцон 173 км-ын аялал хийлээ.



2022 оны ахмад, цолгүй залуу харваачдын үндэсний сурын улсын аварга шалгаруулах тэмцээн 2022.06.18-19-ны өдрүүдэд Зуунмод суманд сурын талбайд амжилттай зохион байгуулагдаж багийн 400 гаруй харваачид оролцлоо.



Монголын үндэсний спортын VII их наадмын хүрээнд уран уургач бугуйлч, эмнэг булгуйлагчдын “Адуучин” тэмцээнийг 2022.06.26-нд Аргалант суманд зохион явуулж 21 сумын 62 тамирчин оролцлоо



Монголын үндэсний спортын VII их наадмын шагайн хавааны шигшээ тэмцээнд оролцох эрхийн төлөөх шагайн харвааны тэмцээнийг 2022.06.18-нд зохион байгуулж 16 багийн 128 харваач оролцож Д.Одбаяр ахлагчтай баг шалгаран шигшээ тэмцээнд оролцох эрхийг авлаа. Бадын бөөрийн тойром шагайн харвааг 2022.06.25-26-нд Эрдэнэсант суманд зохион явуулж 46 багийн 368 харваач оролцож цэц мэргэнээ сорин өрсөлдлөө.



Ливан улсад зохиогдсон Ази тивийн аварга шалгаруулах өсвөр үеийн самбо бөхийн тэмцээнд манай тамирчид амжилттай оролцож охидын 59 кг жинд Д.Номин мөнгө, 65 кг Б.Арвин хүрэл, хөвгүүдийн 58 кг У.Бямбадорж мөнгөн медаль хүртлээ.



Булган аймагт зохион байгуулагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөнгөн атлетикийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 8 хүнтэй баг амжилттай оролцож 3 хүрэл медаль хүртлээ.



Чөлөөт бөхийн өсвөрийн шигшээ багийн 2 тамирчин, дасгалжуулагчийн хамт Бахрейн улсын Манама хотод болох U20 Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход БХБ-ын сайд Мөнхбаатар, болон сум, сургууль нь дэмжлэг туслалцаа үзүүлэн энэхүү тэмцээнд манай чөлөөт бөхийн дасгалжуулагч Л.Энхбаярын дасгалжуулсан Монгол улсын эмэгтэй шигшээ багийн тамирчид 3-р байрыг эзэллээ.



Бага насны улсын аварга шалгаруулах 2019" таеквондогийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 50 гаруй байгууллага 800 гаруй тамирчид өрсөлдсөнөөс Төв аймгийн "Эв Нэгдэл" клуб анх удаа оролцон 3 тамирчин хүрэл медаль хүртсэн.

2022 оны Боксын өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд Төв аймгийн БТСГ-ын дэргэдэх АЛТАН ОД клубээс 3 тамирчин оролцсоноос 1 хүрэл, 1 мөнгөн медаль хүртлээ.

2022 оны өсвөр үеийн засмал замын дугуйн улсын аварга шалгаруулах тэмцээн Зуунмод хот үүсгэн байгуулагдсаны 80-н жилийн ойн хүрээнд төв аймагт 2022.06.20-21-ны өдрүүдэд зохион байгуулагдан 9 байгууллагын 62 тамирчин оролцож манай тамирчид 9 алт, 11 мөнгө, 10 хүрэл медаль хүртэж багаараа 1-р байрыг эзэллээ.



Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах волейболын тэмцээн Дундговь аймагт 2022.06.23-29-ны өдрүүдэд зохион байгуулагдаж манай баг тамирчид амжилттай оролцлоо



НАЙМ. ЦЭРГИЙН ШТАБЫН ХҮРЭЭНД:

2022 оны Цэргийн штабын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн цэргийн анхан шатны сургалтыг 2022 оны 6-р сарын 10-нөөс 10 хоногийн хугацаатай Батлан хамгаалахын сайдын баталсан Цэргийн дүйцүүлэх албаны сургалтыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулж 16 сумын 60 иргэнийг хамруулав.

Сургалтын 30 хувь буюу 3 хоногийн хугацаанд Зуунмод хотын 80 жилийн ой, Төв аймаг байгуулагдсаны 100 жилийн ойг угтан алба хаагчид Зуунмод сумын “Одонт хөтөл цэцэрлэгт хүрээлэн”-д 100 модны нүх ухах, 798 суулгац бортоглох, БНМАУ-ын баатар Д.Самдангийн цэцэрлэгт хүрээлэнд мод тарих, төв цэнгэлдэх хүрээлэнгийн өнгө үзэмжийг сэргээх зэрэг 20 гаруй сая төгрөгийн бүтээн байгуулалтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР